

БҮЛЭГ 1.

Испани. Памплон 1976 он.

"Хэрэв төлөвлөгөө нурвал бид бүгд балрах нь тэр"

Тэр гоомой сул тал байгаа эсэхийг олчих санаатай сүүлчийн удаа нягтлан шалгаж, нэгэнтээ сайтар эргэцүүлэн бодоод өчүүхэн төдий ч өө сэв олсонгүй. Зоримог нь дэндсэн гэмээр эл төлөвлөгөө нь зөвхөн секунд, дойлоор яг таг тооцоолсон нягт нямбай цаг хугацаа шаардах ажээ.

Хэрвээ төлөвгөө нь биелвэл агуу Эль-Сидтэй эн тэнцэх гялалзсан ялалт болно. Харин нурвал ч... Эргэлзэж сэтгэл санаа нь хоёрдон хямрахад нэгэнт оройтжээ хэмээн Хайме Миро тунгаан бодлоо.

Хайме Миро Испани Францын баруун өмнөд дүүргийн иргэдийн дунд домогт баатар болж цууд гарсан, өндөр нуруу, чин зоригт ухаалаг төрх, булчин зангирсан бие бялдар, бодол болсон хар нүдтэй нэгэн билээ.

Түүнийг үзсэн харсан нутгийн ардууд мань эрий өндөр нуруу, харгис догшин царайтай хэмээн дэгсдүүлэн ярих дуртай ч Хайме Миро бол эсрэг этгээдийнхээ давуу талыг дэндүү сайн ойлгодог реалист ч юм шиг, мөн нөгөө талаасаа итгэсэн зүйлийнхээ төлөө амиа өгөхөөс ч буцдаггүйг нь үзвэл романтик ч юм шиг ер нь ойлгоход тун ч төвөгтэй хүн ажгуу.

Памплон хотод хөлгүй их баяр наадам болоход, хотын оршин суугчид тэг чигээрээ галзуурцагасан мэт болцгоодог жил бүрийн 7 сарын 7-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг Гэгээн Ферманы баярын өглөө бослоо. Памплон хотод ертөнцийн өнцөг булан бүрээс 33 мянган зочин заларч ирцгээдгийн ихэнх хэсэг нь ердөө л догширсон буханд элдүүлэн гудамжаар зугтахын хүсэлд автагсдыг сонирхохоор, бусад нь өөрийн биеэр оролцож улангассан амьтны урд гүйн эр зоригоо гайхуулахаар ирдэг байна. Зочид буудлуудын өрөөнүүд аль хэдийн захиалагдаж дууссан байх тул тэдгээр зочид их сургуулийн оюутны байр, галт тэрэгний зогсоол, байгууллагын үүдний өрөө, хотын талбай, тэр ч бүү хэл хотын гудамж, замаар хоноглох газар хайцгаана.

Бүх л кафе, зочид буудлуудад, цаасан наамлаар хийсэн үлэмж биетнүүдийн гойд сайхан сүрлэг жагсаалыг нүд бүлтийн сонирхож, гудамжны найрал хөгжмийн аялгууг чих тавин чагнах жуулчдаар пиг дүүрч, ёстой нэг батганы хошуу багтах зайгүй болжээ. Баярт оролцогчид ногоон, анарын өнгөт болон

БҮЛЭГ 1.

Испани. Памплон 1976 он.

"Хэрэв төлөвлөгөө нурвал бид бүгд балрах нь тэр"

Тэр гоомой сул тал байгаа эсэхийг олчих санаатай сүүлчийн удаа нягтлан шалгаж, нэгэнтээ сайтар эргэцүүлэн бодоод өчүүхэн төдий ч өө сэв олсонгүй. Зоримог нь дэндсэн гэмээр эл төлөвлөгөө нь зөвхөн секунд, дойлоор яг таг тооцоолсон нягт нямбай цаг хугацаа шаардах ажээ.

Хэрвээ төлөвгөө нь биелвэл агуу Эль-Сидтэй эн тэнцэх гялалзсан ялалт болно. Харин нурвал ч... Эргэлзэж сэтгэл санаа нь хоёрдон хямрахад нэгэнт оройтжээ хэмээн Хайме Миро тунгаан бодлоо.

Хайме Миро Испани Францын баруун өмнөд дүүргийн иргэдийн дунд домогт баатар болж цууд гарсан, өндөр нуруу, чин зоригт ухаалаг төрх, булчин зангирсан бие бялдар, бодол болсон хар нүдтэй нэгэн билээ.

Түүнийг үзсэн харсан нутгийн ардууд мань эрий өндөр нуруу, харгис догшин царайтай хэмээн дэгсдүүлэн ярих дуртай ч Хайме Миро бол эсрэг этгээдийнхээ давуу талыг дэндүү сайн ойлгодог реалист ч юм шиг, мөн нөгөө талаасаа итгэсэн зүйлийнхээ төлөө амиа өгөхөөс ч буцдаггүйг нь үзвэл романтик ч юм шиг ер нь ойлгоход тун ч төвөгтэй хүн ажгуу.

Памплон хотод хөлгүй их баяр наадам болоход, хотын оршин суугчид тэг чигээрээ галзуурцгаасан мэт болцгоодог жил бүрийн 7 сарын 7-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг Гэгээн Ферманы баярын өглөө бослоо. Памплон хотод ертөнцийн өнцөг булан бүрээс 33 мянган зочин заларч ирцгээдгийн ихэнх хэсэг нь ердөө л догширсон буханд элдүүлэн гудамжаар зугтахын хүсэлд автагсдыг сонирхохоор, бусад нь өөрийн биеэр оролцож улангассан

амьтны урд гүйн эр зоригоо гайхуулахаар ирдэг байна. Зочид буудлуудын

өрөөнүүд аль хэдийн захиалагдаж дууссан байх тул тэдгээр зочид их

сургуулийн оюутны байр, галт тэрэгний зогсоол, байгууллагын үүдний өрөө, хотын талбай, тэр ч бүү хэл хотын гудамж, замаар хоноглох газар

хайцгаана.

Бүх л кафе, зочид буудлуудад, цаасан наамлаар хийсэн үлэмж биетнүүдийн

гойд сайхан сүрлэг жагсаалыг нүд бүлтийн сонирхож, гудамжны найрал

хөгжмийн аялгууг чих тавин чагнах жуулчдаар пиг дүүрч, ёстой нэг батганы

хошуу багтах зайгүй болжээ. Баярт оролцогчид ногоон, анарын өнгөт болон

алтан шаргал юүдэн бүхий хөх ягаан нөмрөг нөмөрцгөөж, гудамжаар урсан өнгөрөх энэхүү баярт жагсаал солонгын долоон өнгөөр алаглан хөвөрнө.

Энэ өдрийн тулаанд оролцох бухын хамгийн үзүүштэй хэсэг болох оройн тулааныг үзэхээ бүр ч олон хүн цугларчээ.

Омголон догшин бухнуудыг шөнө дундаас арваад минутын өмнө Санта-

Домингогийн гудамжны төгсгөл дэх хашаанаас гарган гүүрэн дээгүүр

туусаар хотын доод хэсэгт орших хашаанд авчирчээ. Өглөө нь өвч модон

хаалгаар тоноглосон Санта-Домингогийн хавчиг гудамж руу суллан тавихад, эдгээр бух гудамжны төгсгөл хүрээд тулааны өмнө тэднийг хоргоон барьж

байх Хэмингуэйн талбай дахь хашаанд очих ёстой ажээ.

Баярт оролцохоор ирэгсэд унтахыг ч умартан сэтгэл нь хөөрцгөөж, тэд шөнө

дундаас эхлэн өглөө болтол дарс шимэн ууцгааж, дуулж хуурдан дарвиж,

тэр ч бүү хэл янаглан дурлацгаана.

Бухтай гүйлдэж энэ биеийн чилээг гаргах гэсэн хэн бүхэн хүзүүндээ Гэгээн

Ферманы час улаан ороолт зүүжээ. Өглөөний зургаад 15 минут дутуу

байхад Наваррын зориг бадруулах аялгуу хангинуулсан найрал

хөгжимчдийн цуваа гудамжаар хөвөрч эхэв.

Яг долоон цагт хашааны хаалга нээгдсэнийг нийтэд зарлан тунхагласан

пуужинг агаарт хөөргөхөд хурсан олон тэчъяадан хөөрцгөөв. Хэдхэн

секундын дараагаар омголон догшин бухнууд гүйлдэж эхэлснийг хот даяар

сануулж хоёр дахь пуужинг хөөргөв.

Хоёр дахь пуужинтай зэрэг шахуу баргийн эр бажга алдмаар аймшигт

адгууснууд ухасхийцгээлээ. Алсад сэвэлзэх салхины чимээнээс үл ялгагдах

төдий чимээ гарснаа төдөлгүй улам тодрон туурайн пижигнэх чимээ огтхон ч сонсогдоогүй байтал тус бүр нь 1500 фут жин өлхөн татах нас бие гүйцсэн зургаан ланжгар шар, зургаан аварга бух гараад ирлээ. Тэд Санта-Домингогийн гудмаар яг л галт тэрэгний хурдтай эн тэнцэхээр аймшигтай хурдаар давхилдав. Хаа сайгүй барьсан модон бэхэлгээний ард зогсох хэдэн арван хөөрцөглөсөн залуус аймшиггүй зоригоо харуулахаар улайрсан бухын улайрсан зам дээр үсрэхээр бэлтгэцгээж харагдана.

Бухнууд Санта-Домингогийн гудамжны тэртэйгээс Лаэст-рафета гудам, Хавьерын дэргэдэх эмийн сан, Хэмингуэйн талбай, ногооны талбайн хажуугаар давхилдахад цугларсан улс томоогүйтэн "Хөөг Хөөг" хэмээн хөөргөн хашхиралдав. Улайрсан бух ойртоход хүмүүс тэдний жад мэт хурц

эвэр, үхлийн аюултай туурайнаас нь эрхгүй нэг дальдарцгаах ажгуу.

Ойртон буй гэнэтийн үхлийн аюулыг ойлгосон зарим оролцогч аврал эрэн

байшингийн орц, галын шат руу ухасхийхийг харсан хэн нэгэн нь олны

дундаас "Хулчгар" хэмээн хашхирах дуулав. Бухны улаан зам дээр бүдэрч

унасан зарим нэгэн нь аюулгүй газар руу годхийн босож гүйх үзэгдэнэ.

Догшин бухын эргэх газраас хэдхэн футын зайтай хашлаганы ард

өвөөтэйгөө зогсох бяцхан хүү айсандаа амьсгаадан цээж нь түмбэлзэн байв.

-Чи хар даа! Сайхан байгаа биз ! хэмээн өвөө нь бахдан бархирахад бяцхан

хүү чацвалзан татганаж,

-Надад аймшигтай байна гэхэд хөгшин хүүг өхөөрдөн тас тэвэрч,

-Тийм ээ, Мануэль. Аймшигтай. Гэхдээ гайхалтай байгаа биз. Би ч гэсэн нэг

удаа бухтай гүйж явсан юм шүү. Ингэж наадахад юутай ч зүйрлэмгүй

мэдрэмж төрүүлдэг юм. Амь насаараа дэнчин тавин байж өөрийгөө жинхэнэ

эр хүнд тооцдог юм шүү гэлээ.

Бухнууд Санта-Домингогийн гудмаар 900-гаад ярд давхисаар хоёр минутын

дараа талбайд хүрч ирэнгүүт тэднийг хашиж аваад агаарт гурван пуужин

хөөргөдөг номтой юмсанж. Гэтэл тэр нэгэн хэргээс болоод 400-гаад жилийн

түүхтэй энэхүү баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлж байсан түүхэнд гарч

байгаагүй явдал Памплонд болж, энэ өдөр гурав дахь пуужин хөөрсөнгүй ээ.

Догшин амьтад нарийн гудамжаар хар хурдаар давхиж явтал ёслолын тод

хувцастай хэсэг хүмүүс хашлага тийш хашхиралдан гүйлдэхэд, бухнууд

гэнэт үргэн хамгаалалттай хашаанаас хотын төв рүү эрх чөлөө эдлэн

дайран орж, нэгэн агшны төдийд ер бусын хөгжилтэй баяр наадам жинхэнэ

аймшиг болон хувирах нь тэр.

Хилэн нь бадарсан адгууснууд алмайрч зогтуссан үзэгчдийн дундуур хага
зүсэн орлоо.

Үзэгчид улангассан буханд мөргүүлэн шидэгдэж, тийрүүлэн бяц гишгэгдэж
эхлэхэд бяцхан хүү өвөөгийнхөө хамт хамгийн эхний өртөгсдийн тоонд
оржээ. Жад мэт хурц эвэр хүүхдийн тэргийг нэвт сүлбэн нялх хүүхдийг
егүүтгээд, дараа нь эхийнх нь гэдсийг хүү татан тэр даруй үхэлд хүргэв. энд
тэндгүй үймээн самуун, үхэл хагацал хөвөрч эхэллээ. Адгууснууд арчаагүй
дорой үзэгчид рүү халдан, хүүхэд эмэгтэйчүүдийг газарт чулуудан

аймшигтай хурц эврээрээ ийш тийш гүйлдэх хүмүүсийг нэвт сүлбэн сийчиж, худалдааны
асруудыг дайрч унаган, замд нь тааралдсан золгүй бүхнийг

хөнөөж, эвдлэн сүйтгэж эхлэв. Айсандаа орилж чарлах хүмүүс үхэл чирэх

адгуусны хөлөөс дайжин зүтгэцгээх ажээ.

бухнццдын зам дээр гэнэт улаан өнгийн ачааны тэрэг гарч ирлээ. Цусанд

улангассан адгууснууд ч гэдрэг эргэн Памплоны шорон руу хөтлөх Де

Эстрелья гудамжаар час улаан ачааны тэрэгний араас хурдлав.

Памплоны шорон нь цонхондоо төмөр сараалжтай, хоёр давхар, баргар

чулуун барилга байлаа. Шоронгийн дөрвөн булан дахь цамхаг дээр, мөн

орох хаалган тушаа Испанийн улаан, шар туг намирна.

Шоронгийн хоёрдугаар давхарт цаазаар авах ялтнуудад зориулсан хорих

өрөөнүүд байрладаг юмсанжээ.

Автомат буу мөрлөсөн, цэргийн цагдаагийн дүрэмт хувцастай лантгар

бүдүүн хамгаалагч эр урт хар өмсгөлтэй гэгээнтнийг дагуулан шоронгийн

хонгилоор явж байв.

Буу зэвсэг харсан гэгээнтний нүдэнд үзэн ядах, сэжиглэнгүй байдал

жирвэсхийн үзэгдэхэд хамгаалагч,

-Сонор сэрэмж илүүдэхгүй ээ ламтаан. Энэ өрөөнүүдэд хамгийн өөдгүй

шаарнууд хориглож байдаг юм гэв.

Хамгаалагч эр онгоцны буудлыг тоноглонтой яг ижил металл хайгч бүхээг

тийш гэгээнтнийг дагуулан аваачиж,

-Өршөөгөөрэй ламтаан, ийм журамтай шүү гэлээ.

-Тэгэлгүй яах вэ, хүү минь.

Гэгээнтнийг металл хайгчийн бүхээгт оров уу, үгүй юу гудамд дохио

хангиналаа. Хамгаалагч эр хар зөнгөөрөө автомат буугаа тас атгав.

Гэгээнтэн гэдрэг эргэн харж инээмсэглэн,

-Энэ миний алдаа гэж хэлээд хүзүүндээ зүүлттэй байх мөнгөн гинжтэй хүнд төмөр загалмайгаа авч хамгаалагч эрд сарвайв.

Гэгээнтэн дахин бүхээгт ороход металл хайгч энэ удаа дуугарсангүй.

Хамгаалагч эр ламтан загалмайг эргүүлэн өгч, хоёул шоронгийн гүн рүү замаа үргэлжлүүллээ. Хонгилын дагуу орших хорих өрөөнөөс тэсвэрлэхийн эцэсгүй орлилдоон гарахад хамгаалагч эр,

-Ламтаан та энд цагаа дэмий үрж байна даа. Таны аврал энэрлээ хайрлаад байгаа эн араатнуудад зүрх сэтгэл гэж байдаггүй юм шүү гэв.

-Гэлээ ч гэсэн бид итгэл алдарч болохгүй ээ, хүү минь хэмээн ламтанг намжирдахад хамгаалагч эр толгой сэгсэрч,

-Танд л гэж хэлэхэд тэр хоёрыг там хүлээгээд үүд хаалгаа аль эрт дэлгэчихсэн байгаа гэлээ.

-Хоёрыг гэв үү! Надад гурвуулаа нүглээ наминчлахыг хүссэн гэсэн шүү дээ.

Хамгаалагч эр мөрөө хавчин,

-Уул нь гурвуулаа байсан юм. Гэтэл Самаро өнөө өглөө цэргийн эмнэлэгт таалал төгссөн. Зүрхний шигдээсээр гэв.

Тэд хамгийн мухрын зэрэгцээ хоёр өрөөнд хүрч очлоо.

-Ирчихлээ ламтан.

Хамгаалагч нэг хаалгыг нь нээгээд, болгоомжтой холдон гэгээнтнийг дотогш оруулж хаалгыг түгжин, гудамд өчүүхэн төдий түгшүүрт явдал гарах аваас ухасхийхэд бэлэн зэхий зогслоо.

Гэгээнтэн баруун талын вандан дээр хэвтэх хоригдол руу дөхөж очоод,

-Нэр чинь хэн бэ хүү минь? гэж асуув.

-Намайг Рикардо Мельядо гэдэг.

Гэгээнтэн хориглол эрийг нухацтай ширтэв. Энэ эр наранд амьдарч байхдаа ямаршуухан байсныг тааж мэдэхийн эцэсгүй харагдах ажээ. Зодож занчуулан цусанд будагдсан нүүр, нүд нь бараг үзэгдэхгүй шахам болтлоо пэмбийж хавджээ.

-Ламтан таныг хүрч ирсэнд баярлалаа гэж хоригдол хавагнасан уруулаа хөдөлгөх төдийхөн хэлэхэд нь,

-Ариун шашны үүрэг бол чамайг аврах явдал юм шүү, хүү минь хэмээн ламтан хариулав.

-Намайг өнөөдөр дүүжлэх үү? гэхэд нь гэгээнтэн түүний мөрийг зөөлөн алгадаж,

-Чамд үхлийн ял оноосон байна лээ гэв.

Рикардо Мельядо түүнийг ширтэж,

-Үгүй ээ! гэж амандаа дэмий л нэг бөвтнөв.

-Надад тун харамсалтай байна. Ерөнхий сайд өөрөө тушаал өгсөн гээд гэгээнтэн хоригдлын толгойд гар хүргэн адислаж нэгэн хэмийн аялгуугаар номлолоо айлдаж эхлэв...

-Би бие болон сэтгэлээрээ ихээхэн нүгэл үйлдсэн, тэгээд ч хийсэн нүгэлдээ чин сэтгэлээсээ гэмшиж байна хэмээн Рикардо Мельядо аяархан өгүүлэв.

Ламтан номлолоо үргэлжлүүлэн дүнгэнэсээр...

Хорих өрөөний үүдэнд зогсож байсан хамгаалагч эр үүнийг чих тавин сонсоод "Цагаа дэмий үрж байна даа. Бурхад түүнийг мөн тоох байх даа" хэмээн эгдүүцэн бодов.

-Бурхан чамайг ивээх болно хүү минь.

Ламтан номлолоо өндөрлөөд үүд тийш явж очиход хамгаалагч хаалгыг нээн түүнийг гарган үүдийг дангинатал түгжлээ. Хамгаалагч цааш эргэн хажуугийн өрөөний үүдэнд очин нээгээд,

-Тэр таны мэдэлд байна, ламтаан гэлээ.

Ламтан хоёрдахь өрөөнд явж оров. Өрөөнд байх хоригдлын нүүрэн дээр мөн л харгис хэрцгий зодуурын ул мөр үзэгдэнэ. Гэгээнтэн түүнийг гяргай харцаар ширтээд,

-Хэн билээ, хүү минь? гэв.

-Феликс Карпио гэдэг.

Хоригдол эр бол хацар, сахал дундуур нь нэвт гарсан шинэхэн хөхөрсөн сорвитой, битүү хууз сахалтай, эрэмгий зоригтой байрын нэгэн байлаа.

Би үхэхээс айхгүй байна, ламтаан.

-Энэ сайн шүү, хүү минь. Бидний хэн нь ч үхлийн савраас мултарч чадахгүй.

Гэгээнтэн Карпиогийн нүглийг наминчлах номлолыг уншиж байтал

шоронгоос тэртээ алс бөглүүт дуу сонсогдож байснаа төдөлгүй бүр ч ойртон

тодорч, тэгснээ улам чангарлаа. Энэ нь тачигнатал давхих туурайн чимээ, амь тавин чарлалдан гүйлдэх хүмүүсийн дуу байлаа. Сэтгэл түгшсэн

хамгаалагч чих тавин чагнавал эл шуугиан улам бүр ойртсоор байх ажээ.

-Ламтаан, түргэлж үзээрэй. Гудамжинд ямар нэгэн базаахгүй явдал болж

байх шиг байна гэж хамгаалагч эр хэлэв.

-Би дуусчихлаа.

Хамгаалагч яаравчлан хаалгыг нээвэл гэгээнтэн хонгил руу гарч ирэхэд

түүний ард хорих өрөөний хаалга хавхийтэл хаагдлаа. Шоронгийн гадаа

тачигнах чимээ гарч байв. Хамгаалагч эр хавчиг торон цонхоор гадагш

гарснаа,

-Чөтгөр ав, юун дуу чимээ вэ? гэхэд нь ламтан,

-Хэн нэгэн нь танд бараалхахаар ирсэн бололтой. Үүнийг чинь авбал та

татгалзахгүй биз дээ? гэв.

-Үүнийг гэж юуг тэр вэ?

-Таны энэ зэвсгийг ээ.

Гэгээнтэн хамгаалагч эрд ойртон очоод, хүзүүн дэх загалмайныхаа тагийг онгойлгон нэгэн зүйлийг суга татан гаргаж ирсэн нь мууг ёрлон гялалзах матигар хутга байжээ. Тэрээр нүд ирмэх зуур матигар хутгаа хамгаалагч эрийн цээжинд ишийг нь далд ортол шааснаа,

-Харж байна уу, хүү минь. Бурхан бид хоёр ярилцаад чамд хойшид бууны хэрэггүй болсон гэж шийдлээ гээд үхэж буй хамгаалагч эрийн гараас автомат бууг нь авлаа.

-Ээ Бурхан өршөө гэгчхээд Хайме Миро загалмайлан залбирав.

Хамгаалагч эр чулуун шалан дээр үхэтхийн уналаа.

Хайме Миро түүний бүснээс түлхүүрийг нь суга татан авч нөгөө хоёр хорих

өрөөний хаалгыг нээв. Гудамжнаас гарах чимээ улам бүр чанга сонсогдсоор байлаа.

-Түргэлээрэй гэж Хайме тэднийг захирамжлав.

Рикардо Мельядо автоматыг шүүрэн авлаа.

-Чи ч овоо дамжгүй гэгээнтэн болох нь дэг ээ. Би бараг итгэх шахсан шүү хэмээн памбайж хавдсан уруулаа хөдөлгөн инээхийг оролдов.

-Та нарыг мөн болгож тавьжээ. Зүгээр ээ. Тэд шангаа хүртэнэ бий вий.

Хайме тэр хоёрыг сугадан түшиж, урт хонгилоор явахад нь туслав.

-Самора яагаа вэ?

-Хуягууд түүнийг үхтэл занчихад яаж орилж бахирсныг бид сонссон. Түүнийг эмнэлэг рүү аваачсаны дараа зүрхний шигдээсээр үхсэн гэж хэлж байна лээ.

Тэд төмөр хаалганд дөхөж очлоо.

-Эндээ хүлээж бай гэж Хайме хэлээд хаалганд тулж очоод хаалганы цаана зогсох хамгаалагчид хандан,

-Би дуусчихлаа гэв.

Хамгаалагч даруй хаалгыг нээв.

-Ламтаан, хурдлаарай. Гудамжинд ямар нэг үймээн...

Тэрээр хэлэх үгээ гүйцээж амжсангүй.

Хаймегийн гар дахь матигар хутга хамгаалагчийн цээжинд шигдэж, амнаас нь цус урсаж эхэллээ.

Хайме нөхөд рүүгээ гар даллан,

-Явцгаая гэв.

Феликс Карпио хамгаалагчийн бууг дээш өргөн бэлэн зэхсээр, тэд шатаар уруудаж эхэллээ. Гудамжинд эм замбараа алдагдаж, цагдаа нар эргэн тойрон юу болоод байгааг ойлгохыг чармайн ийш тийш гүйлдэж, улайрсан бухнаас нуугдан хоргодох газар эрэн зүтгэн ухаан мэдрэлээ алдацгаан орилолдох хүмүүсээс юу болоод байгааг асуухыг оролдоно. Нэг бух шоронгийн чулуун хаалгыг мөргөн дотогш нэвтрэн орж, нэгэн хамгаалагчийг дайрч унагаан дэвслэх үзэгдэв.

Өнөөх улаан өнгийн ачааны тэрэг хашаанд бэлэн зогсож байв. Хар толгойгоо эсэн мэнд авч гарахын тулд ухаан зулаггүй зугтааж байсан хөлгүй үймээн дунд өнөөх гурвыг анзаарах сөхөөтэй хүн байсангүй. Хайме болон түүний нөхөд ганц ч үг дуугаралгүй ачааны машины тэвшин дээр харайлган гарцгаахад машин чигнаалаа орилуулан пиг хүнтэй гудамж руу орж, гудамжинд үймэлдэх хүмүүсийг хага яран зам гаргасаар цааш хурдаллаа. Лакадсан хар бүрхэн ногоон дүрэмт хувцастай нутгийн жандарм цагдаа,

үндэсний гвардынхан ухаан жолоогүй гүйлдэх хүмүүсийг зогсоох гэж дэмий л нэг оролдоцгоох авч тогтоож хүчирсэнгүй.

Улайрсан бухнаас зугтах хүмүүс бие биенээ унагаж, гишгэлэх нь аймшигтай.

Тэдний дийлэнх нь хөгшид, эмэгтэйчүүд байх аж.

Хайме айдас хүрэм үзэгдлийг хараад,

-Би арай ч ийм юм болно гэж тооцоолоогүйсэн хэмээн халаглан дуу алдлаа.

Энэ аймшигтай хядалдааныг зогсоохын тулд юу ч хийж чадахгүй, арчаагүй

байдлаар дэмий л ширтэн явсан Хайме өөрийн эрхгүй зүрх шимширсэн эл

үзэгдлийг харахгүй гэсэндээ нүдээ анилаа.

Сандарч үймэлдэн хашхиралдах дуу ард үлдэж, ачааны тэрэг Памплон

хотыг хөндлөн гарснаа өмнө зүг рүү эргэв.

-Бид хаачиж яваа юм бэ, Хайме? Гэж Рикардо Мельядо асуув.

-Торрегоос холгүйхэн аюулгүй газар очоод, харанхуй болтол тэндээ байж

байгаад дараа нь цааш явцгаана.

Феликс Карпио өвчиндөө ярвайн үрчийв.

Хайме Миро түүнийг өрөвдөн,

-Одоохон очноо, найз минь хэмээн намуухан өгүүлэв.

Тэрээр Памплоны гудамжинд болсон аймшигт үзэгдлийг яагаад ч мартаж

чадахгүй билээ.

Тэд хагас цагийн дараа Торре хэмээх бяцхан тосгоны цаана сүндэрлэх

ууланд ганцаар байх байшинд хүрч очлоо.

Хайме нөхдийнхөө ачааны тэвшнээс буухад нь туслав.

-Шөнө дунд та нарыг авахаар ирнэ хэмэн жолооч эрий хэлэхэд нь Хайме,

-Эмч авчраарай. Наад машинаа хаа нэгтээ хаячихна биз гэв.

Тэр гурав зочдын өрөөндөө ханан зуух, банзан таазтай, тохилог фермерийн байшинд орцгоов.

Ширээн дээр нэг зурвас байсныг Хайме авч уншаад “Миний гэр-Чиний гэр” гэсэн найр тавьсан зочломтгой зурвасыг уншаад инээмсэглэлээ. Бааранд шилтэй дарс байх ажээ. Хайме гурван хундага дүүргэхэд,

-Найз мний, би чамд яаж талархахаа мэдэхгүй байна. Чиний төлөө! гээд

Рикардо Мельядо хундгаа өргөхөд нь,

-Эрх чөлөөний төлөө! гэж Хайме хариулаад хундгаа өргөв.

Гэнэт зочдын өрөөнд байх торноос канар бялзуухай яруу сайхнаар жиргэх дуулдахад Хайме босож, түүн рүү хүрч очин жигүүрээрээ цөхрөлтгүй дэвэх түүнийг хэсэг ажсанаа торны амыг нээн болгоомжтой гэгч нь барьж аваад онгорхой цонхны дэргэд очив.

-Нис дээ, шувуухай минь. Бүх амьтад эрх чөлөөтэй байх ёстой хэмээн

Хайме эелдэгээр хэлжээ.

БҮЛЭГ 2.

Ерөнхий сайд Леопольдо Мартинес тун ууртай байлаа. Намхан нуруутай, нүдэндээ шилтэй түүнийг ярихад нь бүгд айн чичирнэ.

-Энэ муу Хайме Мирог устгах хэрэгтэй. Ойлгов уу, та нар? гэж биедээ баймгүй чанга дуугаар чарлав.

Ерөнхий сайд өрөөнд цугларсан бүгдийг тойруулан хилэгнэсэн харцаар хэсэг харснаа,

-Бүхэл бүтэн армийн цэрэг, цагдаа нар ганц алан хядагчийг барьж чадахгүй байх ч гэж! хэмээн зандарлаа.

Эл хуралдаан Ерөнхий сайдын ажиллаж, амьдардаг Монклоа ордонд болж

байв. Ордон Мадридын төвөөс 50 км-ын зайд Галисын өргөн чөлөөнд

байрлах агаад газрын зураг дээр тэмдэглэдэггүй аж. Тэр ордон төмөр тагт, ногоон хөшиг цонхондоо өлгөсөн, булан бүрдээ манааны цамхаг бүхий

ногоон тоосгон байшин байлаа.

Халуу дүүгэн, агаар хуурайшсан энэ өдөр цонхны цаана хараа гүйцэх газарт

халуун агаар дээш хөөрөн зэрэглээтэн жирвэлзэн байх үзэгдэнэ.

-Миро өчигдөр Памплон хотыг тулааны талбар болгон хувиргаад, шоронгийн

хоёр хуягийг алж, хоёр зандалчнаа суллажээ. Хайме Мирог бухнуудыг

сулласнаас болж олон арван гэмгүй хүмүүс амь эрсэдсэн байна гээд

Мартинес нударга зангидан ширээгээ шаалаа.

Хэсэг зуур хэн ч дуугарч эс зүрхлэн өрөөнд нам гүм болов.

Ерөнхий сайл албан үүргийнхээ дагуу нам гүмийг эвдэн биедээ эрэмшсэн

дуугаар,

-Би эн тэргүүнд энэ салан тусгаарлах үзэлтнүүдийн бүлгийг устгана. Мадрид

хот андалузчууд, баскчууд, каталокууд, галисчуудыг жинхэнэ испаничууд

болгон хувиргасан том төв болох болно хэмээн мэдэгдлээ.

Тэрээр бодлогогүй, хуумгай үзэлтэй нэгэн юмсанж.

Өөрийн тусгаар тогтнолын төлөө цуцалтгүй тэмцэгч догшин баскчууд бөмбөг

дэлбэлэн, банк дээрэмдэж, жагсаал хийн үл номхрох янзтай байжээ.

-Би түүнийг олно гэж Мартинеээс баруунтаа суух нэгэн хүн намуухан

дуугаар өгүүлэв.

Энэ үгийг баскчуудын террористуудтай тэмцэхээр байгуулагдсан “ГОЕ”

хэмээх тусгай бүлгийн хурандаа Рамон Акако хэлжээ. Хурандаа тавь орчим

настай, өндөр нуруутай, нүүрэндээ сорвитой, зэвхий даасан хүйтэн нүдтэй нэгэн ажээ. Иргэний дайны үед залуу офицер байсан тэрээр Франсиско Франкод алба хааж, одоог хүртэл “Бид зөвхөн Бурхан болоод түүхийн өмнө л хариуцлага хүлээнэ” гэсэн гүн ухааныг хэт шүтэгч юмсанж.

Акако Франкод ихэд итгэмжлэгдсэн шилдэг офицер, шилдэг туслахуудынх нь нэг байлаа. Мань хурандаа төмөр хатуу сахилга батыг эрхэмлэж, хэн хууль зөрчинө тэр ял яндраа эдлэх ёстой гэсэн үзэл баримталдаг ажээ.

Тэрээр эвдэж, сүйтгэж, алж хядан, олон орны хүн, цэргийн техникийг дайнд татан оруулж, асар олон хүни алтан аминд хүрсэн иргэний дайны хүнд, аймшигтай он жилүүдийг амсаж өнгөрөөжээ.

Гэтэл одоо баскчууд дайн тулаан үүсгэж, алж хядаж эхэлсэн байна.

Хурандаа Акако терроризмын эсрэг өрөвдөх сэтгэлгүй, тууштай тэмцэгч бүлгийг толгойлж байгаа ажээ.

Түүний хамтран зүтгэгчид олон танигдаагүй, дүр төрхөө нууж ажилладаг, хэзээ ч хөрөг зургаа авахуулж байгаагүй тул тэдний тухай сураг ажиг нийтэд, ялангуяа террористуудын дунд тархаагүй нууцлаг байдаг байна.

“Хайме Мирог зогсоож чадах хүн байдаг юмаа гэвэл тэр нь хурандаа Акако гарцаагүй мөн” хэмээн Ерөнхий сайд бодлоо. Харин хэн Акако хурандааг зогсоох вэ? Гэсэн нэгэн асуулт оньсого хэвээр үлдэнэ.

Ажиллагааны удирдлагыг хурандаа Акакод даалгах санаа нь ерөнхий сайдынх байсангүй. Нэгэн шөнө түүний хувийн утас руу залгасан хүнийг тэрээр дуугаар нь танилаа.

-Бид Хайме Мирогийн үйлдэл, түүний террористуудад ихээхэн сэтгэл

түгшиж байна. Хурандаа Акаког “ГОЕ”-ын тэргүүнээр тавих саналыг танд дэвшүүлье. Та ойлгов уу? гэжээ.

-Ойлголоо. Би энэ хэрэгт санаа тавина.

Ингээд холбоо тасарчээ.

Харанхуй шөнөөр ярьсан тэр дуу хоолой бол бүрэлдэхүүнд нь банкны эзэд, өмгөөлөгчид, томоохон корпорациудын толгойлогчид, Засгийн газрын

сайдууд багтсан “ОПУС МУНДО” хэмээх байгууллагын нууц зөвлөлийн

гишүүдийн нэгнийх нь байлаа. Чих дэлссэн дам сургаас үзэхэд тус

байгууллага асах их мөнгөн хөрөнгөтэй боловч түүний орлогын эх үүсвэр

болон зарлагын тайлан нууц байдаг. Энэ тухай олон юм асууна гэдэг тун ч

бодлогогүй алхам болох нь лавгай ажгуу.

Ерөнхий сайд авсан зааврын дагуу хурандаа Акаког тусгай бүлгийн

тэргүүнээр томилов. Гэтэл энэ улангассан эр улайран зүтгэгч болон хувирч, 10

түүний “ГОЕ” байгууллага нь алан хядаж, ноёрхлоо хаа сайгүй тогтоожээ.

Ерөнхий сайд Памплони ойр хавиас Акакогийн барьсан баскийн үймээн

гаргагч хүмүүсийн тухай эргэн саналаа. Тэднийг буруушаан, цаазлах ял

оноожээ. Хурандаа Акако аажмаар чангарч, нуруу нугасыг нь гэмтээн үхэлд

хүргэдэг төмөр цагираг углан хэрцгийгээр цаазлах ёстой гэж үзсэн ажээ.

Хайме Мирог барина гэдэг хурандаа Акакогийн хувьд өдрийн бодол шөнийн

зүүд нь болоод байжээ.

-Надад түүний толгой л хэрэгтэй. Түүний толгойг тасдмагч баскуудын

хөдөлгөөн нам дарагдана гэж хурандаа бардам амлахад “Энэ ч хөөрүү

сэтгэлийн дэвэргэн бодол байна даа” гээд түүний үг өчүүхэн төдий ч үнэний

хувь үгүй байгааг ерөнхий сайд хүлээн зөвшөөрч “Гэхдээ энэ хурандаа

Акако ч чамгүй аюултай хүн дээ” гэсэн нэгэн гашуун бодолд дарагдав.

-Эрхэм ноёнтоон, Памплонд ийм юм болсон гэж бодоход тун хэцүү байна.

Хайме Миро, тэр ... гэж Үндэсний аюулгүй байдлын албаны ерөнхий захирал

Приито Касадог үг хэлэх гэтэл,

-Хаймегийн хэн болохыг би мэднэ. Түүний хаана байгаа надад сонин байна гэж ерөнхий сайд үгийг нь таслав.

-Би түүний мөрийг олсон. Эрхэм ноёнтоон, бид нэг хүнтэй тэмцэлдээгүй шүү гэдгийг танд сануулах гэсэн юм. Бүх баскчууд бидний эсрэг байна. Тэд Хайме Миро болон тэдний террористуудыг хоол хүнс, зэр зэвсэг, хоргодох байраар хангаж байна. Энэ эр тэдний ардын баатар болчихжээ. Гэвч санаа зовох хэрэггүй. Тун удахгүй энэ баатар дүүжлүүрт өлгөгдөн санжигнаж байх болно. Мэдээж би түүнийг чин шударга шүүхэд өгсний дараа л даа гэж ярих хурандаа Акокагийн дуу тасалгааг ер бусын хүйт оргиулав.

“Бид биш, харин би гээч. Бусад нь үүнийг анзаарсан эсэх нь тун сонин байна. Тийм ээ, хурандаа Акокагийн тухайд нэг юм хийх хэрэгтэй болж дээ” хэмээн ерөнхий сайд цухалдан бодоод өндийн суудлаасаа босч,

-Өнөөдөр ингээд өндөрлөцгөөе, ноёд оо гэлээ.

Хурандаагаас бусад нь ерөнхий сайдын өрөөнөөс цувралдан гарцгаав.

Ерөнхий сайд хурандааг зэрвэс харснаа,

-Хараал идсэн баскчууд! Ерийн нэг испани хүн болоход юундаа шил нь татчихаад байгаа юм бол? Тэдэнд өөр юу хэрэгтэй болчихсон юм бол оо? гэсэн хурандаа,

-Тэд засаглалд санаархаж байгаа юм. Тэдэнд автономит засаглал хэрэгтэй, өөрийн хэл, өөрийн далбаатай ...

-Санасны гарз байлгүй. Би энэ албан тушаалыг хашиж байсан цагт тийм юм болохгүй. Испанийг хэсэглэн хуваахыг би хэзээ ч тэдэнд зөвшөөрөхгүй.

Тэдний эдлэх эрх, үүрэг хариуцлагыг Засгийн газар шийдэх болно. Тэд ердийн л хүмүүс ... гэтэл ерөнхий сайдын үгийг таслан түүний туслахуудын нэг өрөөнд орж ирэн,

-Өршөөгөөрэй, эрхэм ноёнтоон. Хамба лам Ибанес ирлээ хэмээн уучлал эрсэн өнгөөр хэлэхэд ерөнхий сайд,

-Оруулахгун гэв.

Хурандаагийн нүд уйтан болон анийж,

-Танд л гэж хэлэхэд энэ бүхний ард сүм дуган бий. Тэднийг хашраах цаг нь иржээ гээд “Сүм дуганд яагаад ч итгэж болохгүй” гэж хурандаа хорсон бодлоо.

Иргэний дайны эхэн үед католик сүм дуганууд үндэсрхэг үзэлтнүүдийн талд байсан. Ромын Пап генерал Франког дэмжиж Бурхан түүний талд байгаа шүү хэмээн мэдэгдэж байсан бол баскчууд сүм дуган, гэгээнтнүүдийг хавчиж эхэлмэгч тэд бодлоо өөрчилжээ.

Сүм хийдийнхэн баск, католикчуудад эрх чөлөө олгохыг шаардцагаан “Та нар баскийн гэгээнтнүүдийг цаазар авахаа зогсоо” гэж тулган шаардах болов. Үүнийг сонсмогц генерал Франко “Шашин номынхон Засгийн газарт хэрхэхийг зааж яаж зүрхлэх нь энэ вэ” хэмээн галзууртлаа хилэгнэжээ.

Туйлдуулж, тамирдуулсан дайн эхлэв.

Генерал Франкогийн дайчид сүм хийд рүү довтолж гэлэн санваартнуудыг хүйс тэмтэрч эхэлжээ. Хамба ламтнууд гэрийн хорионд орж, Испани даяарх гэгээнтнүүд үймээн самуун сурталчлан номлосныхоо төлөө Засгийн газарт торгууль төлөх болжээ.

Сүм хийпдийнхэн Франког хөнөөсөн тэр үеэс тэдэн рүү халдан довглохыг зогсоосон аж.

“Хараал идсэн сүм, хийд. Франкогийн үхлээс хойш тэд дахиад л энд тэндгүй хошуу дүрж явцгаадаг болжээ” гэж Акока бодно.

-Испанийг хэн удирдаж байгааг сүм хийдийнхэнд мэдүүлэх цаг нь болжээ гэж тэрээр Ерөнхий сайдад хэлэв.

Эцэнхий дорой царайг нь хүрээлсэн үүлэн цагаан үстэй хамба ламтан Калво

Ибанес нүдний хавчуурт шилнийхээ цаанаас тасалгаанд байгсдыг гяргай гүйлгэн ажиглав.

-Оройн мэнд, гэнээн хамба ламтаан гэж Ерөнхий сайд мэндлэв.

Санваартныг харсан даруйдаа хурандаагийн хоолой бачуурч, дотор нь

оргилох уур цухал юу юугүй дэлбэ үсрэн гадагшлахад тун ойрхон байгааг хурандаа Акока мэдэрлээ.

Акока тэднийг тэнэг ишигнүүдээ нядалгааны газар руу тууж яваа ухна мэт

зэвүүцэн үздэг болжээ.

Хамбатан тэднийг суухыг урьтал нь хүлээн зогслоо. Гэтэл өрөөний эзэн

урьж суулгасангүйгээр үл барам хурандааг ч танилцуулсангүй, эс

тоомсорлож буйгаа зориуд үзүүлэх мэт дүр эсгэв.

Ерөнхий сайд эхэл гэсэн янзтай харц хурандаа тийш чулуудахад нь

хурандаа,

-Бидэнд тун түгшүүртэй мэдээлэл ирлээ гэж үерийн ус сад тавив уу гэлтэй

яриагаа огцом эхэлснээ,

-Баскийн үймээн дэгдээгчид католик шашны сүм хийдэд цуглаан зохион

байгуулж байгаа тухай, мөн шашны байгууллагын зөвшөөрлөөр хийдүүд

босогчдын зэр зэвсгийг нууж байгаа талаар бидэнд мэдэгдсэн гэснээ тэрээр

төмөр хяхнах мэт дуугаар үргэлжлүүлэн,

-Испанийн дайснуудад тусалснаар та нар өөрсдөө түүний дайсан болж

хувирна шүү хэмээн өгүүлэв.

Хамба ламтан түүнийг гярхай гэгч нь харснаа ерөнхий сайд Мартинест

хандан,

-Эрхэм ноён сайд аа, таныг гүнээ хүндэтгэх үүднээс бид бүгд Испанийн үр

сад гэдгийг хэлэх ёстой. Баскчууд бидний дайсан биш ээ. Тэд ердөө л эрх

чөлөө гуйж ... гэтэл,

Тэд зүгээр ч нэг гуйгаагүй. Тэд шаардаж байна! Тэд дээрэм хийн, банк

тонож, улс орон даяар цагдаа нарыг алж талж байна. Ийнхүү эрээ цээргүй

авирлаж байхад та тэднийг бидний дайсан биш гэж хэллээ гэж үү? хэмээн

хурандаа архирав.

-Үл тэвчим, дэглэм эвдсэн явдал гарах болсон гэдгийг би хүлээн зөвшөөрч байна. Гэвч заримдаа тэмцэлд өөрийн итгэл найдварын төлөө ... гэж хамбыг эхэлтэл,

-Тэд хар толгойноосоо өөр юунд ч итгэдэггүй улс. Испанид юу болж байгаа нь тэдэнд огт падгүй хэрэг. Манай агуу их зохиолчдын нэг “Испанид толгой хоргодож байгаа хэн ч нийтийн эрх ашгийн төлөө санаа тавьдаггүй юм. Сүм дуганууд, баскууд, католикчууд бүгд өөр өөрийн ашиг сонирхлоор хөөцөлдөцгөөдөг юм” хэмээн хэлсэн байдагсан гэж хурандаа үгийг нь таслав.

Хурандаа Акока арми, Засгийн газрын тухай хачин далд утгаар дурсан сануулах боловч хэрсүү ухаантай хамба ламтан үг дуугарсангүй. Тэрээр арай илүү бүтээлчээр ярилцах болов уу хэмээн найдан дахин ерөнхий сайдад хандан,

-Эрхэм дээдэс ээ, Католикийн сүм хийд ... хэмээн ярьж эхэлтэл ерөнхий

сайд мөн л үгийг нь таслан,

-Хамбатан та биднийг буруугаар бүү ойлгоорой. Зарчмын хувьд мэдээж

Засгийн газрын зүгээс католикийн сүм хийдүүдийг дэмждэг шүү гэлээ.

Харин хурандаа Акока,

-Сүм хийд дуганыг бидний эсрэг ашиглахыг бид хэзээ ч зөвшөөрөхгүй. Хэрэв

баскчууд цаашид сүм хийдэд зэр зэвсгээ нууж, өөрсдийн цуглаанаа хийсээр

байвал балгийг нь та нар л хар толгойгоороо хариуцах болно доо хэмээн

шазганав.

-Таны сонорыг мялаасан энэ мэдээлэл баттай биш гэдэгт би итгэлтэй

байна. Гэсэн ч би үүнийг үтэр түргэн заавал ч үгүй шалгах болно хэмээн

хамба туйлын тайвнаар хэллээ.

-Гялайлаа танд, эрхэм хамба хэмээн ерөнхий сайд амандаа бөвтнөв.

Ерөнхий сайд Мартинес, хурандаа Акока хоёр хамбын гарч явахыг хүлээж

байснаа,

-Та одоо юу хэлмээр байна? гэж Мартинес хурандаагаас асуувал,

-Тэр юу болоод байгааг бүгдийг нь сайн мэдэж байгаа хэмээн хурандаа

эгдүүцэн хэллээ.

Ерөнхий сайд гүн санаа алдаж “Тэртэй тэргүй хөөцөлдөх асуудал ихтэй

байхад шашин номынхонтой түнжин хагарах нь надад бас дутаж гэнэ дээ”

гэж бодов.

-Хэрэв сүм хийд баскчуудын талд байгаа бол бидний эсрэг байна гэсэн үг.

Таныг болгоовол би энэ муу хамбыг сургаад өгөхсөн гэхэд нь ерөнхий сайд,

-Сүм хийд босогчдод тусалж байна гэж та үнэхээр бодож байна уу? хэмээн

болгоомжтой асуулаа.

-Тэгэлгүй яах вэ, эрхэм дээдэс ээ.

Энэ хүний үнэн хэлж байгаа эсэхийг магадлаж үл болно. Аюулаа сүм хийдийг ямар ихээр үзэн яддаг болох нь ерөнхий сайдад илэрхий боллоо. “Магадгүй Аюулаа нэг их чармайлт гаргалгүйгээр сүм хийдийг номхотгож орхивол юу нь муу байх вэ дээ” гэж бодолхийлэн зогслоо.

Аюулаа хурандаа,

-Сүм хийд террористуудыг удаа дараа нуун далдалж байна. Тэгэхээр тэднийг шийтгэх ёстой гэж шазуур зуун өгүүлэв.

Ерөнхий сайд алгуурхан толгой дохингоо,

-Хурандаа та нэгжлэг хийж эхлэх хэрэгтэй гэж үзэж байна уу? хэмээн асуухад нь,

-Өчигдөр Хайме Миро болон тэдний хүмүүсийг Авилад байхыг нь харсан байна. Тэд үнэхээр тэндхийн орон нутгийн сүм дуганд нуугдаж байж магад

гэж хурандааг хэлэхэд сайд нэгэнт шийдэж,

-Хийдийг нэгжигтүн! гэж тушаалаа.

Эрхэм ерөнхий сайдын гаргасан энэхүү шийдвэр Испанийг төдийгүй дэлхий дахиныг ч цочирдуулсан үйл явдлын эхлэл болжээ.

БҮЛЭГ 3

Авила хот.

Бурханы онцгой номлол сонсгодог хийд нь Мадридаас 112 км зайд,

Испанийн хамгийн өндөр газарт орших Авила хотод байрладаг. Уг хийдийн дэг жаягийг 1601 онд анх баталсан агаад уншлага, шашны зан үйл, ганцаар амьдрах дэг, чив чимээгүй нам гүм орчин нь хүртэл олон зууны турш огт өөрчлөгдсөнгүй өнөөг хүрч чадсан байна.

Энэ хийдэд дөчөөд гэлэнмаа амьдардаг ажээ.

Уг хийд иргэний дайны жилүүдэд болон олон зууны туршид Испанид сүм хийдийг хавчиж гадуурхаж, нэг бус удаа сүйтгэж байхад азаар хадгалагдан үлдсэн долоон хийдийн нэг нь юмсанж.

Чанд номлолтой хийдийн амьдрал бүхэлдээ залбиралд зориулагдан жилийн эргэх улирал, цаг нар мөн чанараараа байдаггүй цорын ганц газар нь энэ хийд бөгөөд босгыг нь алхан тийшээ орсон хэн ч бай гадаад ертөнцөөс үүрд тусгаарлагдан тэндээ үлддэг ажээ. Хийдийн амьдрал нь өдөр бүрийн бясалгал, наминчлал, бурхан тахих үйлд зориулагддаг байна.

Гэлэнмаа нар бусад хийдийнхтэй ижилхэн эрт урьдын бэлгэдэл болсон юүдэн бүхий нөмрөг нь гэм зэмгүй энгийн байдлыг илтгэх ёрог даавуун өмсгөл нь хорвоогийн аж явдлаас татгалзан номхон хүлцэнгүй явах, мөрөн

дээгүүр ноосон эдийн өөдсөөр хийсэн мөрөвч нь цуцалтгүй хөдөлмөрлөх бэлгэдлийг илтгэсэн хувцсаа өмсөцгөөж, эцэст нь зөвхөн нүүрээ ил гарган хөвөн даавуугаар толгойгоо ороон хүзүү рүүгээ унжуулах ажээ.

Хийдийн шат хонгил нь өөр хоорондоо гүнцэг барих танхим, мөргөлийн дуган, бунхнаар холбогдох бөгөөд хаа сайгүй хүйтэн зэврүүн, цэвэрхэн атлаа хоосон уур амьсгал ноёрхоно. Өндөр ханын эргэн тойрон дахь зузаан шилтэй торон цонх нь цэцэрлэг тийш харж, торлосон цонх бүр нь даяанч гэлэнмаа нарыг юунд ч сатааруулахгүйн тулд өлмийгөө өргөөд ч гадагш харж чадахааргүй өндөрт байрладаг ажээ. Урт нарийхан, хатуу дэг жаягтай гүнцэг барих танхимын цонхыг самбараар хаан, хөшиг татжээ. Хуучны лааны суурин дахь лаанууд сүүмэлзэн анивалзаж, хана таазан дээр хачин маягийн сүүдэр тусна.

Дөрвөн зууны туршид хийдийн хананы цаадах оршин суугчдын царай
 зүснээс өөр хийдийн ганц ч юм өөрчлөгдсөнгүй. Бурханы үнэнч шавь болсон
 гэлэнмаа нар хувийн эд хогшил гэх юмгүй, олон жилийн өмнө хэн ч билээ
 нэгэн баян эрхмийн бэлэглэсэн цэвэр алтаар урласан үнэлж баршгүй
 загалмайг эс тооцвол хийдэд ч гэсэн нүдэнд торж гялайх засал чимэглэл гэх
 юу ч үгүй. Хэдийгээр энэ алтан загалмай нь хатуу чанд ёс жаягт үл нийцэх
 авч түүнийг гүнцгийн өрөөн дэх жижигхэн шүүгэнд хадгалж, харин хийдийн
 гол ширээндээ ерийн нэг модон загалмай өлгөөтэй байж ажээ.

Өөрийн амьдралаа бурханд зориулсан эмэгтэйчүүд хамт амьдарч, ажиллаж,
 хооллож, хамтдаа залбирцгаах авч, хэзээ ч бие биесээс хамаардаггүй, үг
 дуу ч үгүй номлолоо сонсож, гэгээн эх-даа гэлэнмаа Бетина өрөөндөө
 дуудуулан ам нээн ярилцах боломж гарсан байлаа ч тэд толгой дохин
 зангах төдийхнөөр хэл солилцдог байна.

Эх-даа гэлэнмаагийн нас сүүдэр хэдийнэ дал гарсан ч гэлээ хийдийн аз
 жаргалтай, амар амгалан амьдрал, бурхан шүтээндээ үнэнчээр зориулан
 буй амьдралдаа сэтгэл хангалууныг илтгэх түүний зүс царай урам зориг, эрч
 хүчээр дүүрэн гэрэлтэнэ. Тэрээр гэлэнмаа нартайгаа ихэд хичээнгүйлэн
 харьцах бөгөөд тэднийг яалт ч үгүй гэсгээн шийтгэх цагтаа шийтгүүлж буй
 хүнээсээ дор шаналдаг нэгэн.

Гэлэнмаа нар хэлхгэр ханцуйндаа гараа далдлан энгэр тушаанаа зөрүүлж,
 гудамж хонгилоор харц доогуур алхлах зуураа эгч дүү гэлэнмаа нартайгаа
 тааралдах авч үг дуугарах нь бүү хэл, өчүүхэн төдий ч анзаарсан янзгүй
 зөрцгөөнө. Сүм хийдийн ийм нам гүмийг Виктор Гюгогийн “Дуурийн гонхон”

хэмээн нэрлэсэн хонхны дуу л гагцхүү эвдэх ажгуу.

Гэлэнмаа нар янз бүрийн замаар энд ирсэн бөгөөд өөр өөрийн түүх намтартай. Тэд сурвалжит, фермийн эзний, цэргийн ... гээд янз бүрийн гарал угсаатай, янз бүрийн орчноос хийдийг зорин иржээ. Хөлгүй баян, эсвэл үгээгүй ядуу, боловсролтой, бас мунхаг харанхуй, ариун шударга, эсвэл шалихгүй нэгэн явсан эд бүгд одоо бурханы мэлмий дор эс ялгаран тэгш харагдаж, бурханы үнэнч эгч дүүс байх цорын ганц хүсэлд эвсэн нэгджээ.

Христийн хийдийн амьдрал дэндүү хатуу дэгтэй юмсанж. Өвөлд нь яс

янгинам хүйт дааж, элч муутай үлбэгэр гэрэл бараан саарал цонхыг арай

ядан нэвтлэн бүүдийнэ. Гэлэнмаа нар сүрлэн ширдэг дээр бүхлээрээ унтаж, зузаан ноосон бүтээлгээр хучна. Хүн бүр ор, түшлэгтэй модон сандал бүхий

хавчиг өрөөтэй агаад угаагуурын тосгуурын оронд өрөөний булангийн

шалан дээр жижигхэн шавар домбо, түмпэн хоёр байх аж. Эх-даа

Бетинагаас бусад гэлэнмаа нар бие биесийн өрөөнд орох хориотой.

Тэд бүхий л цагаа борви бохисхийлгүй ажиллах, залбирахад зориулна. Гар нэхээс, сүлжмэл эд нэхэх, талх барих ажил хийцгээн, өдрийн найман цагт залбирал үйлдэнэ.

Өглөөний урьтал залбирал, хорвоогийн тал хэсэг унтаж, нөгөө хэсэг нь нүгэл үйлдэж байх тэр мөчид шөнө дундын цагаар уншигдана.

Түүний дараагийн үүрийн таван жингээр агуу бурханы гэгээн дүрийг гийгүүлэх ургах наранг угтан өглөөний уншлага залгаж, гэгээн бурхандаа амин чухлаа даатгадаг аж.

Гэгээн Августинад сүлдэд айлтгах гурван залбирал нь өглөөний есөн цагт, 11 цагт, хуял тачаал гаарч дэврэхийг багасгах секстаг үдээс хойш, гурван цагт ноно залбирал үйлдэж, эцэст нь оройн мөргөл залгана.

Христийн хийдийн амьдрал шоронгийнхоос илүү хатуу атлаа гэлэнмаа нар хорвоогийн арван хар нүглийг амсахгүй байгаадаа ухаангүй баярлацгаах ажээ. Тэд янаг амрагийн явдал, эд хөрөнгө, сонгуулийн эрх чөлөө эд бүгдийг хөсөр орхин татгалзсаны хамтаар хомхой сэтгэл, өрсөлдөөн, үзэн ядалт, хорвоогийн амьдралд хаа сайгүй байдаг дарангуйлал, дур татсан эрээн бараан явдал бүхнээс тусгаарлагдаж чаджээ. Бурханд нэгдсэн тэсгэлгүй баяр хөөрт уур амьсгал, тийм нэгэн ертөнц хийдийн хаа сайгүй ноёрхох ажгуу. Тэгээд ч энд толгой хоргодогсдын хэнийх нь ч зүрх сэтгэл туйлын амар амгаланд умбана. Хэрэвзээ хийд шоронтой адил юмаа гэвэл шорон нь бурханы энхжингийн орон болж таарах нь ээ. Наашаа ирсэн хэн боловч толгой хоргодсоны хойт дээр мөнхийн аз жаргалыг ойлгомгоц сайн дураараа

Энэхүү амьдралыг сонгодог буйзаа.

###

Гэлэнмаа Лючия хийдийн хонхны дуугаар сэрлээ. Бүсгүй цочин татганаж, нүдээ нээмэгц хэсэг зуур хаана байгаагаа эс ойлгон гайхширчээ. Түүний унтаж буй бяцхан өрөө мууг ёрлох мэт харанхуй оргино. Хонхны дуун өглөө гурван цаг болж шөнийн алба нь эхэлж буйг зарлах энэ мөчид хорвоо ертөнц тэр аяараа амгалан нойрсож байлаа.

“Хараал ид гэж! Энэ дэг жаяг намайг залхааж гүйцлээ” хэмээн гэлэнмаа Лючия бодов.

Бүсгүй галзуу улаанаа ганц сайн баагиулах тэсгэлгүй хүсэлд автан, тохь муутай хавчиг орондоо хэвтэж байснаа биеэ хүчлэн арай ядан босов.

Унтахдаа хүртэл тайлдаггүй гэлэнмаагийн салбарсан хувцас нь түүний

булбарай зөөлөн арьсыг зүлгүүр мэт үрэх ажээ. Бүсгүй Рим дэх байр,
Гстаадын харшид өлгөөтэй байгаа гял цял болсон палаажнуудаа саналаа.

Гэлэнмаа Лючиягийн чихэнд гудамд цуглах гэлэнмаа нарын хөлийн чимээ,
салбагар хормойн шар шархийх сонсогдов. Бүсгүй ороо хайш яйш хураан
эмхэлсэн болоод гэлэнмаа нар аль хэдийнэ цугларан газар шагайн эгнэн
зогссон урт гудам тийш гарлаа. Гэлэнмаа нар цувралдан бунхан тийш
аажим хөдөлцгөөв.

“Эд яг л тэнэг оцон шувуудын сүрэгтэй адил юм” хэмээн Лючия бодлоо. Энэ
бүсгүйчүүд яагаад өөрийн амьдралыг зориуд цэглэн хорвоогийн жам ёсны
секс, ганган дэгжин хувцас, амттай тансаг хоолноос татгалзаж байгааг
тэрээр үл ойлгох аж. “Энэ бүхэнгүйгээр амьдрана гэдэг ямар утга байна! Бас
тэгээд энэ хараал идсэн дэг жаяг юу ч билээ” хэмээн Лючия эгдүүцлээ.

Лючияг дөнгөж хийдийн босго алхсан тэр өдөр эх-даа гэлэнмаа түүнд,
-Чи толгой гудайлгаж, гараа ханцуй дотроо шургуулан ойр ойрхон удаан
алхаж явах ёстой. Чи эгч, дүү гэлэнмаа нартай харц солилцох нь бүү хэл
харах ч ёсгүй. Чамд ярихыг зөвшөөрөхгүй. Чиний сонор зөвхөн бурханы
үгийг сонсох ёстой гэжээ.

-За, эх гэлэнмаа.

Хийдэд сар байх хугацаандаа Лючия,

-Бусадтай нийлж харьцах гэж энд ирдэггүй, харин бурхантай аглагт байх гэж
наашаа ирцгээдэг юм. Бурхантай холбогдоход биш сэтгэлийн ганцаардал
зайлшгүй хэрэгтэй байдаг. Энэ нь чив чимээгүй байх гэсэн дүрмээр
захирагддаг номтой гэсэн зэмийг хүртээд авчээ.

-За, гэгээнтээн.

-Чи Ион Крестилийн гэгээн номлолоор өөрийн мэдрэхүйтэй тэмцэх ёстой.

-Мэдлээ, эх гэлэнмаа.

-Гэлэнмаа нар тэнгэрийн оронд заларсан мэт чив чимээгүй, ганцаардмал амьдрах ёстой. Гэлэнмаа нарын шунан хүсч байдаг энэ эцэс төгсгөлгүй туйлын нам гүмд л тэрээр бурханы үнэн мөнийг таньж чадна.

Хийдэд нэг сар амьдарснаас нь хойш Лючиягийн үсийг хусч гэлэнмаагийн сахил хүртээв. Энэ үйл түүнд хүндхэн дурсамж үлдээжээ. Эх-даа гэлэнмаа өөрөө түүний үсийг гардан хусчээ. Тэрээр бүсгүйг өрөөндөө дуудуулж суу хэмээн дохиод ард нь гармагц юу болж буйг ухаарахын завдалгүй байтал хайч дуугарах сонсогдон, ямар нэг юм үсийг нь зулгаахыг Лючия мэдэрсэн аж. Бүсгүй эхлээд эсэргүүцэх гэснээ, энэ нь зөвхөн гадаад төрхийг нь өөрчлөхөөс цаашгүйг ойлгон:

“За яах вэ, одоохондоо зумласан тахиа шиг явж л байг, би санааныхаа зоргоор ургуулж чадах юм хойно” гэж боджээ. Тэрээр өөрийн уйтгарт торонд эргэж ирээд: “Энэ газар надад могойн үүрийг санагдуулж байна шүү” хэмээн зүхнэ. Өрөө нь банзан шалтай, модон хатуу ор, сандал хоёр давчуу өрөөнийх нь ихэнх зайг эзэлжээ. Бүсгүй сонины тасархай ч гэхнээ олж уншихсан хэмээн тэчъяадан хүсч, “Сонингийн тасархай эндээс олдох болов уу” хэмээн хайх мэт ийш тийш харав. Энд сонин хэвлэлийн тасархай бүү хэл сураг ч сонсогдож байгаагүй, тэр ч бүү хэл телевиз, радионы тухай дурсдаггүй, гадаад ертөнцөөс бүрэн таслагджээ.

Гэхдээ байгалийн жам ёсноос гажууд амаа үдэн дуугүй байх нь бүхнээс илүү Лючияг цухалдуулна. Харьцааны арга болсон дохио зангааг нэг бүрчлэн цээжлүүлэх нь түүнийг галзууруулах дөхнө. Шүүр хэрэгтэй гэвэл баруун гараа урагш сунган яг л хог шүүрдэж буй мэт зүүн, баруун тийш савчих ёстой гэж түүнд заажээ.

Эх гэлэнмаа сэтгэл дундуур байвал бусад хуруунуудаа тас атгаад хоёр гарын чигчий хурууг гурвантаа нийлүүлэн тогшдог ажээ. Лючия даалгасан ажлыг нь цалгардуулж байвал эх гэлэнмаа баруун гараа зүүн мөрөндөө хүргэнэ. Нэг удаа Лючияг зэмлэхдээ хуруунуудаа хагас атгаад баруун талын чихний орчим нүүрээ маажихад нь Лючия “Ээ бурхан минь, үүнийг чинь бөөстчихөж л гэж ойлгомоор юм байна даа” гэж боджээ.

###

Тэд бунханы дэргэд цугларч, гэлэнмаа нар дуу шуу ч үгүй залбирч эхлэхэд Лючия бүсгүй “Сарын дараа цагдаа нар намайг эрж хайхаа болиход нь би

Энэ тэнэг байшингаас зайлна даа” хэмээн бурханаас ч илүү чухлыг бодно.

Лючия өглөөний үйлээ дуусгасны хойно гэлэнмаа нарын хамтаар гүнцэг барих танхимд орон хийдийн хатуу дэг жаягийг зөрчин тэдний царайг сэм ажигладаг байв. Энэ нь түүний хийд дэх амьдралын цорын ганц зугаа болдог байлаа.

Эгч дүү гэлэнмаа нар нь ямар шуу улс болохыг тэдний хэн нь ч мэдэхгүй байгаа гэж бодоход нэг л итгэмээргүй, байж боломгүй санагдана.

Гэлэнмаа нарын царай зүс түүний сонирхлыг ихэд татна. Тэдний дунд хөгшин, залуу, хөөрхөн, муухай царайтай янз янзын эмэгтэйчүүд байх агаад тэд бүгд яагаад ийм аз жаргалтай байгааг Лючия нэг л ойлгож ухамсарласангүй. Тэдний дундаас гурван гэлэнмаа сонирхлыг нь гойд татна. Нэг нь тавь эргэм намны Тереза гэлэнмаа. Тэрээр тийм ч царайлаг

байгаагүй ч гэлээ нүүрнээс нь гэрэлтэх цог заль нь түүнийг ер бусын сэтгэл татам болгох аж. Тэрээр ямар нэг ид шидийн нууцыг мэддэг юм шиг цаг үргэлж дотроо инээж явах нь сонин.

Лючиягийн сэтгэлийг татдаг бас нэг гэлэнмаа нь гуч эргэм насны цэвэрхэн бор царай, тас хар гялалзсан нүдтэй хачин царайлаг Грасиела ажээ. “Энэ алга урвуулахын зуур кино од болж чадна даа, гэвч чухамдаа энэ хэний охин гээч юм бол? Тэр яагаад энэ ноохойд өөрийгөө амьдаар нь оршуулна вэ?” хэмээн Лючия гайхдаг байв.

Лючиягийн сонирхлыг татаад байгаа бас нэг гэлэнмаа нь цэв цэнхэр нүд, шаравтар хөмсөгтэй, дэрвийсэн шаргал сормуустай Миган гэгч байв.

Тэрээр харваас гучаад насны толиотой тунгалаг царайтай нэгэн байв.

“Тэр энд юу хийж байгаа юм бол оо? Ер нь энэ хүүхнүүд энд юу хийж суудаг байна? Цоожтой хананы цаана, хавчиг торонд суун ой гутам хоол идэж, ханатлаа унтах нь чөлөөгүй залбирал үйлдэж, борви бохисхийлгүй ажиллаж байх ч гэж дээ. Магадгүй тэд жирийн хүмүүс биш, лав толгойдоо сумтайдаг аа”.

Тэд эргэж хургах ч үгүй амьдралынхаа эцсийн мөчийг хүртэл эндээ ёрдойн байх заяа төөрөгтэй бол Лючиягийн хувьд байдал тэдэнтэй зүйрлэх ч юм биш, тэрээр ганц хоёр сарын дараа гэхэд эндээс ангижирна.

“Бүр гурван сар болсон ч яах вэ. Эндээс өөдтэй нуугдах газар хаанаас

олдов гэж дээ. Эрт зугтахын хэрэггүй. Хэдэн сарын дараагаар

цагдаагийнхан намайг эрж хайхаа болино. Тэр цагт эндээс гарч, мөнгөө

Швейцариас гуйвуулж авч чадсан цагтаа баларч хоцорсон энэ газрын тухай

ном бичих болох л юм байна шүү”.

###

Хэд хоногийн дараа эх-даа гэлэнмаа цаас авчруулахаар бичиг хэргийн өрөө

рүү Лючияг заржээ. Лючия алтан боломжийг ашиглан тэнд хадгалагдаж

байгаа баримтыг халт ч гэхнээ үзэх хорхойгоо дарж чадалгүй хэрэгт дурлан

бичиг баримтыг ухаж байгаад үйлдэл дээрээ баригдчихжээ.

Ширээт гэлэнмаа Бетина олон таван үг хэлэлгүйгээр “Чи буруугаа хүлээн, нүлээ наманчил” гэж дохилоо. “За, гэгээн эх минь” гэж Лючия мөн л үг

дуугаралгүй дохиогоор хариулаад толгой гудайлгав.

Бүсгүйг өрөөндөө эргэж ирснээс хойш хонгилоор явж буй гэлэнмаа нар

агаар хага яран, салхи исгэчүүлэх ташуурын дуу олонтаа тас няхсийн

улихыг сонсчээ. Гэвч тэд чухамдаа Лючия гэлэнмааг ороолгуулж байгаа

гэдгийг хэрхэн мэдэх билээ.

“Ийм “цэнгэл” яс маханд нь тултал номхотгож дардаг л юм байгаа биз. Гэсэн ч намайг номхотгоно гэвэл горьдсоны гарз даа” хэмээн бүсгүй шүд зуун бодов.

Гүнцэгийн танхимд урт хоёр вандан ширээний араад дөч шахам гэлэнмаа эгнэн суух аж. Бие махбод нь махсавч хийдэд махан төрлийн идшийг хориглон цагаан хоол хэрэглэдэг байлаа. Үүр цүүрээр аяга цай юм уу, кофе хэдэн ширхэг хатаасан талхтай өгнө. Үдийн хоолонд хэдхэн ширхэг ногоо хөвсөн усан шөлөөр өл залгуулж, хааяа нэг бага үдийн цайнд өдрийн од шиг жимсний бараа харуулах ажээ.

-Бид өөрсдийн махан биеийг биш, бурханы ариун лагшинг аргадан тойлох гэж энд суугаа билээ хэмээн ширээт гэлэнмаа Лючияд нэгэн удаа хэлжээ.

“Миний муур ч өглөөний цайндаа ийм юм иддэггүй юм шүү. Би энд хоёрхон сар суухдаа дор хаяж таван кг хаясан байх. Ёстой л нэг бурханы сэдсэн сувиллын газар гэлтэй юм гээч”

Цайлж дуусмагц хоёр гэлэнмаа сав суулга угаах модон торхтой ус барьсаар ширээний өнцөгт авчирч тавихад нь ширээний ард суугаа гэлэнмаа нар өөр өөрийн тавгийг тэр хоёрт өгч, өнөөх хоёр гэлэнмаа тавгийг нь гялалзтал угааж, арчаад буцааж өгнө.

Олон таваг дамжуулан угаасан ус нь загалтан, тос хөвөх боловч энэ бол цээрлэж жигших юмгүй, жирийн л нэг үзэгдэл мэт байх аж.

“Эд нар насаа энд барах юм гэж үү” хэмээн гэлэнмаа Лючия зэвүүцэн бодсоноо “За яах вэ, миний хувьд гомдоллоод байх юм алга. Бүх насаараа

хоригдох ялаас энэ нь дээр байлгүй яах вэ” гэж өөрийгөө тайтгаруулна.

Хүүхэн тамхины төлөө юугаа ч, амь насаа ч өгөхөд бэлэн байлаа.

###

Бурханы амар амирлангуйд оршин суух гэлэнмаа нараас хоёрхон км-ийн

зайд хурандаа Акокагаар толгойлуулсан тусгай хэлтсийнхэн хийд рүү

довглохоор зэхэж байлаа.

БҮЛЭГ 4

Хурандаа Рамон Акока анчны төрөлхийн зөн совинтой хүн. Тэрээр мөрдөн

мөшгин хөөх ухаангүй дуртай ч гэлээ, хөнөөн авлахдаа туйлын таашаал

хүртдэг ажээ. Мань эр найз нарынхаа нэгэнд “Би цус үзэх дуртай. Гэхдээ юу алж байгаа нь чухал биш. Буга, туулай, хүн ч байсан ялгаагүй. Хэн нэгний амийг тасалж байвал би өөрийгөө бурхан мэт санадаг юм” хэмээн хуучилж байсан удаатай нэгэн.

Акока хэзээ ч билээ цэргийн тагнуулын албанд хашиж эхэлсэн агаад төд удалгүй гялалзсан авьяас билгээрээ шилдэг офицер хэмээн цууд гарчээ.

Тэрээр ухаантай, аймшиггүй зоригтой, өрөвдөх сэтгэлгүй гэх эдгээр чанаруудаараа генерал Франкогийн гарын туслахуудын нэгнийх нь мэлмийд өртөж, анхаарлыг нь татжээ.

Акоза урьд үзэгдээгүй гайхамшигтай амжилт гаргаж, гурван жил шахам алба хашсан дэслэгч цолтойгоор Фракогийн шпбат элсэн оржээ. Түүнийг Франкогийн алан хядагчдыг эсэргүүцэх зорилгоор байгуулагдсан тусгай бүлгийн явган цэргийн тэргүүнээр томилов.

Яг дайны үеэр ОПУС МУНДО-гийн гишүүдийн нэг Акокатай ярилцахаар дуудуулжээ.

-Бид генерал Франкогийн хэлсний дагуу тантай уулзаж байгаа гэдгээ мэдэгдэх ёстой.

-Мэдлээ, эрхэм ээ.

-Хурандаа, бид таныг ажиглаж байгаа. Тэгээд ч таны талаар таатай сэтгэгдэл бидэнд төрөөд байна.

-Гялайлаа, эрхэм ээ.

-Яваандаа та маш нууц гэмээр тусгай даалгавар биелүүлэх болно.

Нөгөөтэйгүүр тун аюултай ажил шүү.

-Ойлгож байна, эрхэм ээ.

-Бид тун ч олон дайсантай улс, ялангуяа бидний гүйцэтгэж буй ажлын чухлыг үл ойлгогч этгээдүүдийн дундаас тэр шүү дээ.

-За, эрхэм ээ.

-Заримдаа эдгээр хүмүүс бидэнд саад болно, үүнийг бид хэрхэвч зөвшөөрч болохгүй.

-Тэгэлгүй яах вэ, эрхэм ээ.

-Бид яг л тан шиг хүнд найдаж болно гэж би санах юм, хурандаа. Бид бие биенээ ойлголцоно гэж бодож байна.

-Тийм ээ, ноёнтоон. Би үүнийг гүн хүндэтгэл гэж үзэж байна.

-Бид таныг армидаа үлдэхийг хүсэж байна. Энэ нь бидэнд нэн тааламжтай байх болно. Яваандаа бид танд онцгой даалгавар даалгах бодолтой байгаа.

-Баярлалаа, ноёнтоон.

-Бидний дунд болсон ярианы талаар та хэнд ч хэлэх ёсгүй.

-Тэгэлгүй яах вэ, эрхэм ээ.

Акока ширээний ард суух энэ хүнийг хараад ихэд сандчина. Тэрээр түүнд ер бусын айдас төрүүлэх ажгуу.

###

Хурандаа Акока ОПУС МУНДО-гийн зүсэн зүйлийн олон ч даалгаврыг гүйцэтгэсэн бөгөөд даалгаврууд нь ч түүнд хэлсэнчлэн маш нууц, тун эрсдэлтэй байжээ.

Даалгавар гүйцэтгэж явах зууртаа хурандаа Акока нэгэн сайхан гэр бүлийн дур булаам бүсгүйтэй танилцжээ. Энэ мөчигй хүртэл тэрээр цэргийн лагер хэссэн янхан хүүхнүүдийг л мэддэг, тэднийг эс тоомсорлон зэвүүцэж, хэрцгий ханддаг байлаа. Тэдний зарим нэг нь түүнийг хүчээр шахам эзэмдээд, үнэн сэтгэлээсээ түүнд дурлачихдаг агаад тийм хүүхнүүдийг Акока өчүүхэн төдий эс өрөвдөнө.

Харин Сузана Серредилья бол тэс өөр ертөнцийн хүн. Бүсгүйн эцэг Мадридын их сургуульд багш, эх нь өмгөөлөгч хүн байлаа. Арван долоон настай Сузана боловсорч гүйцэж буй бүсгүйн бие хаа, тэнгэрийн эх мэт хонгорхон царайтай ажээ. Рамон Акока урьд хожид энэ балчир бүсгүйтэй зүйрлэх хүнтэй учирч яваагүй бөгөөд түүний сэтгэл уярам дорой байдал нь мань эрийг огтын авьяасгүй мэт санагдаж байсан наалинхай зантай болгож орхижээ. Бүсгүйн эцэг, эх нь Акокаг үл мэдэх атлаа татгалзаагүйд нь мань эр Сузанад ухаангүй дурлачихжээ.

Өөр ямар ч бүсгүй эдэлж үзээгүй мэт тэдний бал сар тун ч амттай өнгөрлөө.

Хүүхэн эзэмдэхийг тэрээр олонтоо үзсэн атал хайр дурлал, тачаал хоёр

хуар нийлэн зохицсон нь түүний хувьд цоо шинэ зүйл байв.

Хуримласнаас гурван сарын дараа Сузана хөл хүндтэй болсноо дуулгаж тэр нь Акокагийн хувьд өгүүлж барамгүй баяр хөөр авчиржээ. Эл баярт мэдээн дээр нь хачир нэмэх гэсэн мэт түүнийг Кастильбланко хэмээх жижигхэн үзэсгэлэнт хотод алба хашуулахаар томилжээ.

Энэ явдал улс үндэстнүүдийн тэмцэл чинээндээ тулж байсан 1936 онд болжээ.

Нэгэн нам тайван ням гаригийн өглөө Рамон Акока залуу эхнэрийн хамт тосгоны төв талбайд кофе уун амарч суулаа. Санамсаргүй байтал талбай дээр баскчуудын жагсаал цуван орж ирэх үзэгдэв.

-Чи гэртээ харьсан нь дээр шиг байна. Замбараагүй байдал үүсэх нь бололтой гэж Акока эхнэртээ хэлэв.

-Чи яах вэ? гэж эхнэрийгээ асуухад,

-Чамаас гуйя. Би яах ч үгүй хэмээн хариулав.

Байдал түгшүүртэй боллоо.

Рамон Акока эхнэр нь олны хөлөөс холдон хийдийг чиглэн явахыг хараад дотор нь уужирлаа. Бүсгүй хийдийн үүдэнд дөхөж очих яг тэр мөчид, санамсаргүй байтал үүд нь дэлгэгдэж эх захгүй буудаж, зэвсэглэсэн баскчууд харайлган гарч ирлээ. Эхнэр нь мөндөр мэт буух суманд хяргуулан үхэдхийн унахыг харсан Акока сандарсандаа хэрхэхээ мэдэхгүй хөшиж орхилоо. Чухам тэр өдрөөс хойш тэрээр баскчууд болон сүм хийдийнхнээс өш хонзонгоо авахаар тангараглажээ.

Ийнхүү тэрээр Авилагийн хийдийн дэргэд “Одоо эдний ээлж болсон” хэмээн эгнэгт шийдэж зогсож буй нь энэ ээ.

Үүр цайхын өмнөх бүрэнхийд нам гүм оргих хийдэд Тереза гэлэнмаа баруун гартаа ташуур тас атган өөрийгөө цөхрөлтгүй ороолгож, зангилааны үзүүр арьсанд нь гүн шигдэхэд тэрээр гэмээ наминчлан чив чимээгүй залбирна.

Гэвч золтой л дуу алдан бархирсангүй. Хэдийгээр дуугүй байхыг тэвчихийн эцэсгүй байсан ч гэлээ гэлэнмаа шүдээ зуун тэсэх ажээ. “Бурхан минь, миний нүгэл хилэнцийг өршөөж хайрла. Таны тушаан зарлигдаж, миний амссан цээрлэлийн гэрч болж, эрээн алаг болсон биеийг минь хараач” хэмээн залбирна.

Өвдсөндөө тэрээр золтой л ухаан алдсангүй. Бас дахин өөрийгөө гурвантаа ташуурдаад орон дээр пидхийн унаад өгчээ. Тэрээр өөрийн биеийг цусан нялга болтол тамлахыг хүссэнгүй. Хөдлөх тоолонд нь янгинан өвдөхөд нь

шүд зуун ярвайсаар өчүүхэн ч гэлээ нүгэл хилэнцэд шийтгэл байх ёстойг бодон ташуураа хар гэрэнд нь хийж байдаг газарт нь буцаан аваачиж тавилаа.

Өөрийгөө цээрлүүлээд байгаа Тереза эгчийн хийсэн нүгэл гэвэл тэрээр өглөө жаяг ёсоор харц буулган хонгилоор орон, Грасиела эгч рүү яаравчлан очиж яваад санамсаргүйгээр түүний царайг харчихсан аж. Тереза эгч тэр даруй хийсэн нүглээ эх-даа Бетинад өөрийн биеэр уламжилжээ. Эх-даа гэлэнмаа буруушаан хөмсөг зангидаж, буруу үйлдэл шийтгэл эдлэх ёстой хэмээн баруун гарын нударга зангидан түүний хоёр мөрөнд ээлжлэн хүрч дохижээ.

Тереза эгч орон дээрээ хэвтээд санамсаргүй харсан бүсгүйн ер бусын

үзэсгэлэнтэй царайг ой ухаанаасаа хөөн арилгах чадал нь эс хүрэх ажгуу.

Тэрээр амьдралын эцсийн мөчийг хүртэл түүнтэй юу ч ярихгүй, нэг ч болов удаа эгцлэн харахгүй гэдгээ, мөнхүү гэлэнмаа нар ойртон дотносох төдийд хатуухан шийтгэдгийг сайн мэдэж байв. Гэлэнмаа нар ямар ч хүйстэнтэй харьцах хориотой, бие болон санаа сэтгэлээрээ даяанчлан амьдрах ёстой.

Хамт ажилладаг гэлэнмаа нар өөр хоорондо үг дуугардаггүй бөгөөд харьцаанаасаа таашаал авч байхыг нь ширээт гэлэнмаа анзаарвал тэднийг даруй салгах ба эгч дүү гэлэнмаа нар нэг ширээнд хамтдаа суухыг бас хориглох ажээ. Хийдийн гэлэнмаа нарын нөхөрсөг харьцааг “онцгой нөхөрлөл” хэмээн булзааруулан нэрлэж үтэр түргэн, тун хатуугаа шийтгэн цээрлүүлдэг байв.

Тереза гэлэнмаад тэртээ алсаас бүдэгхэн сонсогдох хонхны дуу Бурхан түүнийг буруушаан эмлэж буй мэт санагджээ.

Хонхны дуу зэргэлдээ өрөөнд унтаж буй Грасиела гэлэнмаагийн зүүдэнд орж ирлээ. Нүв нүцгэн Мавр түүний зүг ойртонн ирэхэд, бүсгүй түүний бэлэг эрхтэн гандайн боссон байхыг хартал тэр эр бүсгүйн зүг гар сунгаж ...

Грасиела гэлэнмаа ер бусын хачин зүүдэндээ цочиж сэрээд нүдээ нээвэл зүрх нь цээжиндээ багтахгүй оволзож байв. Тэрээр айн ийш тийшээ харвал өөрийн муу умгар өрөөнд орь ганцаар хэвтэж байх ба түүнд сонсогдох цорын ганц чимээ нь тайвшруулах мэт жингэнэх хонхны дуу байлаа.

Грасиела орныхоо дэргэд өвдөг сөхрөн сууж “Бурхан минь, өнгөрснөөс минь салгасанд баярлалаа. Чиний ертөнцөд амсаж буй миний баяр баясгалангийн төлөө чамд баярлалаа. Чиний орон гэрт байх хувь заяаг

надад өгөөч. Чиний гэгээн мэлмий дор үүрд байхыг болгоож ажаамуу. Чиний зүрх сэтгэлийн уйтгар гунигийг хөнгөлөхийг минь зөвшөөрөөч” хэмээн залбирч эхэллээ.

Грасиела гэлэнмаа залбирч гүйцээд ороо нямбайлан хураагаад эгч дүү гэлэнмаа нарын цуваанд жагсан, өглөөний албаа гүйцэтгэхээр бунхан тийш чимээгүйхэн хөдөлцгөөв.

Бүсгүй асаасан лааны танил болсон үнэр, цагийн аясаар элэгдэж гөлгөр болсон чулуу сандаал угласан хөл дор нь гишгэгдэхийг мэдэрлээ. Гэлэнмаа Грасиела хийдэд ирсэн тэр цагт ширээт гэлэнмаагийн хэлсэн “Гэлэнмаа гэдэг бүгдээс татгалзсан-эмэгтэй хүн шүү” гэж хэлж байсны учрыг ойлгоогүй аж. Грасиела гэлэнмаа тэр үед 14 настай байсан бол одоо 17 хүрч

ширээтийнхээ хэлсэн үгийг санааг ойлгохтойгоо болжээ. Чухамдаа даяанчлан амьдарч тэрээр оюун санаа, сэтгэл зүрхээ нэгтгэжээ. Энд өнгөрүүлсэн өдрүүд нь туйлын амар амгалан байх ажээ.

“Дээд тэнгэр эцэг минь, өршөөн нигүүлсэнд тань баярлалаа. Намайг үл умартан орхиогүйд тань баярлалаа. Чамгүйгээр би өөрийн аймшигт өнгөрснийг даван ... Танд баярлалаа. Танд баярлалаа ...”

Үүр шөнийн уншлагаа дуусмагц гэлэнмаа нар үүр цайх хүртэл өөрсдийн умгар өрөөндөө эргэн ирж дараагийн албаа хүртэл дуг хийхээр эргэн ирцгээжээ.

###

Хурандаа Акокагаар удирдуулсан отряд харанхуйгаар хийд тийш яаравчлан дөхөж, Акока хүмүүстээ хандан,

-Хайме Миро болон түүний үймээн гаргагчид зэвсэгтэй. Тэд зэвсгээ хэрэглэнэ гэдэг нь гарцаагүй хэмээн хэлэв.

Хийдийн нүсэр хаалгыг харсан даруйд зэвсэглэсэн баскчууд харайн гарч ирж асан нөгөө хийд санаанд нь орж, суман мөндөрт цохиулан унаж буй Сузана нүдэнд нь үзэгдэх шиг болов.

-Мирог амьд барих албагүй шүү хэмээн тэрээр нэмж өгүүлэв.

###

Миган гэлэнмаа нам гүмд цочин сэрлээ. Нэг л ер бусын, агаар хүртэл хөдөлгөөнд орсон хачин нам гүм байх аж. Тэрээр хийдэд суусан жилийн туршид огт сонсоогүй чимээ анир сонсогдон, түүний зүрх ямар нэг аймшигтай явдлыг зөгнөн дэлсэх аж.

Гэлэнмаа харанхуйд сэмээрхэн босч, өрөөнийхөө үүдийг нээлээ. Хонгил тэр чигээрээ эрчүүдээр дүүрсэн байхыг хараад нүдэндээ итгэсэнгүй.

Ширээт гэлэнмаагийн өрөөнөөс нүүрэндээ сорвитой, нүсэр биетэй эр гарч ирэн эх-даагийнх нь гараас чирэхийг харсан Миган энэ бүхнийг айдаст автан хараад “Энэ аймшигтай зүүд байна. Энд ямар ч эр хүн байх ёсгүй” хэмээн бодлоо.

-Та нар түүнийг хаана нууж байна? гэж хурандаа Акока эх гэлэнмааг

байцаав.

Эх-даа Бетинагийн царайд айдас хүйдэс царцан,

-Чимээгүй! Та нар бурханы ордонд байна. Та нар ариун ордныг бузарлаж

байна гэж түүний хоолой чичигнэж сонсогдоно.

-Гэлэнмаа гуйа надад Миро л хэрэгтэй байна.

Энэ зүүд биш байлаа.

Бусад өрөөнүүдийн үүд нээгдэн, сандарч мэгдсэн царайтай гэлэнмаа нар

гарч ирцгээв. Хийдийн амьдрал тэднийг ийм гэнэтийн үйл явдалд эс

сургажээ.

Хурандаа Акока чирч явсан ширээт гэлэнмааг хажуу тийш түлхэж орхиод

өөрийн баруун гар болох Патрисио Арриетад хандан,

-Эндхийн нүх сүв бүрийг нэгж. Таазнаас аваад шалыг нь хүртэл хэмээн

тушаав.

Акокагийн хүмүүс бунхант тасалгаа, гүнцэгийн өрөө, гэлэнмаа нарын умгар

өрөө гээд хийдийг бүхэлд нь онгичин ухаж, унтаж байгаа гэлэнмаа нарыг

хүртэл орноос нь ховх татан босгож, хонгилоор туусаар бунхант тасалгаа

тийш орууллаа. Гэлэнмаа нар үг дуугарахгүй байх сахилынхаа дагуу тэдэнд

үг дуугүй захирагдах нь дуугүй кино гарч байгаа мэт.

Хурандаагийн хүмүүс өс хонзон авахын туйлд хүрсэн байлаа. Тэд бүгдээрээ

фалангистууд бөгөөд иргэний дайны үед хийдүүд нүүр буруулан, тэдний

хайртай генерал Франкогийн эсрэг эсэргүүцэгч нарыг хэрхэн дэмжиж

байсныг сайн мэднэ. Ийнхүү тэд яаж ийгээд өшөө авах боломжтой сэжүүр

хайцгаана.

Гэлэнмаа нарын шүд зуун тэвчиж, дуугүй байх нь тэдний уур цухлыг улам бадраажээ. Аюула нэгэн тасалгааны дэргэдүүр гартал чарлах дуу гарахаар тийш харвал түүний хүмүүсийн нэг нь гэлэнмаагийн хувцсыг тасар татан урж байлаа. Мань эр дуу шуугүй дэргэдүүр нь өнгөрлөө.

###

Лючия гэлэнмаа эр хүний чанга дуунаар цочин сэрэв. Бүсгүй ухаан алдтал айн сандарчээ. “Цагдаа нар намайг олчихлоо. Даруйхан зугтах хэрэгтэй” хэмээн юуны түрүүнд бодов. Хийд цорын ганц хаалганаас өөр гарах гарцгүй. Хүүхэн ухасхийн босоод гадагш шагайвал хонгилд харагдах энэ нэгэн дүр

зураг түүнийг цочирдуулж орхилоо. Хонгил цагдаа нараар биш, харин дүрэмт хувцастай зэвсэглэсэн хүмүүсэр бөөстөж, ширээ зулыг эвдэн нурааж, хаа сайгүй эмх замбараагүй ноёрхож, ийм тийш үймүүлэн сандаачиж явах үзэгдэв.

Эвдэж сүйдсэн эмх замбараагүй дунд эх гэлэнмаа Бетина зогсон, хайртай хийдийг нь хэрхэн доромжлон бузарлаж буйг гөлийн ширтэж, чимээгүйхэн залбирна.

Миган гэлэнмаа, бас Лючия ч эх-даагийн дэргэд явж очин,

-Ямар чөт ... Энд юу болоод байна? эд хэн юм бэ? гэсэн нь түүний хийдэд ирснээсээ хойш анх удаа ам нээн дуугарч буй нь ажээ.

Гэлэнмаа эх баруун гараа суган доогуур гурвантаа нудран “нуугд” хэмээн нүд нь бүлтэлзэн дохив.

Лючия тээнэгэлзэн түүнийг ширтэн харснаа,

-Одоо ярьж болно. Бурханыг бодож эндээс түргэхэн зутгаая. Зөвхөн бурханыг бодож шүү гэлээ.

Туслах Патрисио Арриета Акока дээр хар гүйхээрээ хүрч ирээд,

-Хурандаа бид бүгдийг нэгжлээ. Хайме Мирогийн ч, түүний хүмүүсийн ч ул мөр алга гэхэд нь,

-Нэгжлэгээ үргэлжлүүл гэж Акока зөрүүдлэн тушаав.

Яг энэ үед эх-даа гэлэнмаа хийдийн цорын ганц нандин эрдэнийн тухай гэнэт санан Тереза гэлэнмаа тийш яаран очиж,

-Надад чамд өгөх даалгавар байна. гүнцэгийн өрөөнөөс алтан загалмайг авч Мендав хийдэд хүргэж өг. Чи түүнийг эндээс авч гарах ёстой. Хурдалж

үзээч! гэв.

Гэлэнмаа Терезагийн жанчных нь хормой хүртэл чичигнэж, хамаг бие нь учиргүй салгалж чичрэн, нүд нь бүлтэлзэн учиргүй сандарсан харцаар эх-даа гэлэнмааг ширтлээ. Тереза гэлэнмаа сүүлийн гучин жилийг хийдэд өнгөрөөж байгаа тул хийдээс гарна гэдэг бодол түүний ухаанд нэг л багтсангүйд гараа өргөн үүнийг хийжж болохгүй хэмээн дохилоо.

Ширээт гэлэнмаа цөхөрч гүйцээд,

-Загалмай эн ад шуламнуудын гарт орж болохгүй, тэгэхээр бурханы нэрийн өмнөөс үүнийг хий гэлээ.

Тереза гэлэнмаагийн нүд гэрэлтэж, бахдалтайяа цээжээ тэвхийлгэн нуруугаа эгцэлж “Бурханы нэрийн өмнөөс” хэмээн дохиод цааш эргэн

гүнцэгийн өрөө рүү хурдлав.

Грасиела гэлэнмаа тэдэнтэй нийлэн, эвдэлж сүйтгэсэн бүхнийг сандран

харна. Акокагийн хүмүүс улам догшрон, гарт тааралдсан болгоноо хэмх

цохин эвдэлж, харин эрхэм хурандаа гуай болж буй явдлыг өөгшүүлэн харж

зогслоо.

-Та нар юу болж байгааг мэдэхгүй л дээ, гэвч би бол ч долоон уулын

цаагуур зугтъя гэж бодож байна гэж Лючия хэлээд Миган, Грасиела руу

харлаа.

-Та нар явах уу? хэмээн Лючия лавлан асуувал нөгөө хоёр гэлэнмаа юу

хэлэхээ эс мэдэн бэгцийн зогсоно.

Тереза гэлэнмаа даавууны өөдсөнд боосон ямар нэг юм барьчихсан тэдэн

дээр яаран шожиг шожиг алхалсаар хүрч ирэхэд, Акокагийн хүмүүс

гэлэнмаа нарыг гүнцэгийн өрөө тийш тууж байлаа.

-Явцгаая гэж Лючия хэлэв.

Хэсэг зуур алмайрсан Тереза, Миган, Грасиела гурав Лючиягийн араас

нүсэр том хаалга руу эргэлээ. Тэд урт гудмын эцэс хүрэн булан тойрмогц

хаалга нь хэдийнэ сэг болтлоо эвдэрсэн байхыг харав.

Санаандгүй байтал газрын гаваас гараад ирэв үү гэлтэй хурандаагийн

хүмүүсийн нэг өмнүүр нь хөндөлдөн,

-Авхай нар хол явах нь уу? буцаад, миний нөхөд та нарт гайхалтай юм

үзүүлнэ гэж хашхичив.

-Бидэнд чамд өгөх бэлэг бий шүү хэмээн Лючия үл тоомсорлон хэлснээ

жоготой гэгч жуумалзан инээж, хатавчны өрөөнд уртаас нь тавьсан байдаг

ширээн дээрээс нэгэн хүнд төмөр лааны суурийг авч дээш өргөв.

Нөгөө эр эргэлзэн түүн рүү харж,

-Тэгээд наадхыг чинь яах болж байна? гэж асуув.

-Ингэх гэж байгаа юм гээд Лючия хамаг чадлаараа далайн тархин дундуур

нь буулгаж орхисонд нөгөөх эр ухаан алдан шалан дээр пидхийн уналаа.

Гурван гэлэнмаа айн сүрдэн зогсоход Лючия,

-Хөдөлж үзээж! гэж тэдэнд тушаалаа.

Төд удалгүй Миган, Лючия, Грасиела, Тереза дөрөв хаалгаар өнгөрч,

шөнийн одот харанхуйд гарч ирлээ.

Лючия зогсосхийн,

-Ингээд би та н арыг орхилоо. Та нарын хойноос эрж хайх болно. Тиймээс

амьтай голтой дээрээ эндээс зайлж үзцэгээ хэмээгээд тэрээр гэдрэг эргэн хийдээс алсхан харагдах уул тийш алхах зуур “Эднийг нэгжлэгээ хийж залхтал би тэнд нуугдаад, дараа нь Швейцарь руу арилж өгнө. Энэ малнууд нуугдаж байсан толгой хоргодох газрыг минь түйвээчихлээ” гэж боджээ. Бүсгүй цаашлан бага шиг дов толгод өгсөөд, ийш тийш ажигласнаа гэдрэг эргэн харвал, байж боломгүй юм, өнөө гурван гэлэнмаа нь хийдийн үүдэнд баримал хөшөө шиг гурван хар юм ёрдойн зогсож үзэгдэх нь тэр. “Ээ чөтгөр гэж, бурханыг бодож, бариад авчихаагүй байгаа дээр нь наанаасаа зайлдаг болоосой, хурдлаач” хэмээн амандаа үглэв.

Тэд байрнаасаа хөдлөх ч тэнхэлгүй байгаа бололтой ***** гадас шиг зогсоцгооно. Удтал хийдэд шавилсан гэлэнмаа нарын орчинтойгоо харьцах хандлага нь бүрмөсөн буурч, юу болоод байгаагаа ч ухаж ойлгож чадахгүй, газар гөлийн сэхээрэх ч тэнхэлгүй болтлоо цочирдон зогсоцгоох ажээ.

Бурханы ариун хийдэд өчнөөн жилийг барж, гадаад ертөнцөөс тусгаарлан байсан авралын хананыхаа гадна зогсож байгаадаа тэд үнэхээр сандарч, хаашаа явж, хэрхэхээ ч мэдэхгүй байлаа.

Хийдийн ханан доторх тэдний амьдрал эртнээс тогтсон заншлаар хооллож, хувцаслаж, юу хийхийг нь зааж өгөн, жаяг ёсны дагуу амьдарч байсан. Гэтэл энэ жаяг дэг нь гэнэт үгүй боллоо. Бурхан тэднээс юу хүсээ вэ? Тэр бодлоо өөрчиллөө гэж үү? Тэд биеэ аль байдгаараа хумин, юу ч ярихгүй, бие биеэ ч харалгүй яг л оцон шувуу шиг бэгцийн зогсоно.

Гэлэнмаа Тереза хулчигнан байснаа алсад харагдах Авила хотын гэрэл тийш заан “Тийшээ” хэмээн дохив.

Тэд тээнэгэлзэнгүй хотын зүг шийдэж ядан хөдөлцгөөлөө.

“За үгүй дээ, маанагууд минь! Хамгийн түрүүнд та нарыг тэндээс хайж эхэлнэ шүү дээ. Энэ ч та нарын л хэрэг л дээ. Надад өөрийн төлөө санаа тавих асуудал хангалттай байна” хэмээн өндрөөс тэднийг ажиглаж байсан Лючия бодов. Бүсгүй тэднийг өөрсдийн мөхөл рүүгээ, гарцаагүй үхэл рүүгээ яву буйг хэсэг зуур ажиглаж байснаа “Хараал идмэрүүд” гэж хараав.

Бүсгүй хад чулуунд бүдчсээр яаран уруудаж, тэдний араас гүйхэд хүнд жанч нь хөдлөхөд саад болох ажээ.

-Хүлээгээрэй, зогсооч! хэмээн Лючия хашхирав.

Гэлэнмаа нар зогсож түүн тийш эргэхэд Лючия амьсгаадсаар тэдэн дээр хүрч ирээд,

-Та нар тийшээ явж болохгү. Тэд та нарыг юун түрүүнд хотоор эрнэ. Та нар өөр газарт нуугдах хэрэгтэй гэв.

Гурван гэлэнмаа таг дуугүй түүнийг ширтэнэ.

-Ууланд гарья гээд Лючия тэсвэр алдан,

-Уул өөд гарах хэрэгтэй байна. Намайг дагаад яв гээд шууд эргэн уул руу чиглэх алхахад гэлэнмаа нар хэсэг зуур зогтуссанаа, ар араасаа цувралдан түүний араас хөдөлцгөөв.

Лючия тэднийг хоцорчих вий хэмээн байн байн эргэн харсаар явлаа. “Би бусдын хэрэгт хошуу дүрчихэв үү дээ? Би эдний төлөө санаа зовох албагүй. Хамтдаа явна гэдэг бүр ч аюултай” хэмээн бодоод арагш хялам хяламхийн харсаар уул өөд өгсөв.

Уул өөд өгсөх гэдэг гэлэнмаа нарын тухайд нэлээд хүндхэн даваа болж, тэднийг хоцорч эхлэхэд Лючия зогсоосхийн хүлээх зуур “Би өглөө гэхэд эднээс салж амрана аа” хэмээн бодож явав.

-Алив түргэлж үзээч! гэж Лючия тэссэнгүй хашгирлаа.

###

Хийдийн нэгжлэг дуусч, цусанд хутгалдаж, урагдаж салбарсан хувцастай гэлэнмаа нарыг цуглуулан туусаар таних тэмдэггүй бүхээгтэй тэргэнд чихэж суулгав.

-Эднийг Мадрид руу миний штабт хүргэ. Наадуулаа тусгайлан хориорой хэмээн хурандаа Аkoa тушаав.

-Ямар ялаар ...

-... террористуудын хань хамсаатан.

-Мэдлээ, хурандаа гэж Патрисио Арриета хэлснээ, үгээ бага зэрэг сунжруулан,

-Дөрвөн гэлэнмаа зугтсан гэж нэмж илтгэхэд нь, хурандаа Акокагийн нүд жартайж,

-Тэднийг ол гэж бархирчээ.

Хурандаа онгоцоор Мадридад эргэн ирж ерөнхий сайдад,

-Хайме Миро биднийг хийдэд очихоос өмнө нуугдаж амжжээ гэж илтгэхэд нь,

-Мэднэ, би сонссон гэж Ерөнхий сайд Мартинес толгой дохин өгүүлэв.

Тэрээр бүр анхнаасаа л Хайме Миро тэнд байхгүй гэдэгт ер эргэлзээгүй ажээ. Хурандаа Акока хийдэд хэрцгийлэн дотволсон нь эсэргүүцлийн догшин шуургыг улам гааруулан дэгдээх нь тэр ээ.

-Болсон явдалтай холбоотой хэвлэлийнхний дайралтын учрыг би өөрөө олно гэж ерөнхий сайд үгээ шилж ядан хэлэхэд,

-Хэвлэлийнхэн террористуудыг баатар болгон дөвийлгөж байна. Тэднийг бидэнд дарамт үзүүлэхийг зөвшөөрч болохгүй хэмээн Акока хөрзгөр царайлан өгүүлэв.

-Тэд Засгийн газарт нэлээд төвөг удах нь ээ дээ. Бас тэр дөрвөн гэлэнмаа ... хэрэвзээ тэд хэлд орж эхэлбэл ч ...

-Санаа бүү зов. Тэд хаа холдох вэ. Би тэднийг баривчилж, Мирог олохдоо л олох болно.

Ерөнхий сайд цаашид аз сорихын хэрэггүй хэмээн үзээд,

-Хурандаа, таны хорьж цагдаж байгаа 36 гэлэнмаатай аятайхан харьцах талаар өөрийг тань биелэн анхаарахыг би хүсч байна. Би армид Мирог болон бусад үймээн гаргагчдыг олох тушаал өгнө. Та хурандаа Состелогийн хамт ажиллах болно гэлээ.

Удтал түгшүүртэй, чимээгүй байсны эцэст,

-Бидний хэн нь ажиллагаа удирдах вэ? Хэмээн Акока мөс мэт хүйтэн нүдээрээ ярилцагч эрийн зүг ширтэн асуув.

Ерөнхий сайдын гол дээр юм горойгоод ирэх шиг болон аягүйцэж,

-Мэдээ та байлгүй яах вэ гэжээ.

###

Үүр цайхын алдад Лючия болон гурван гэлэнмаа Авила хотоос, уулан дахь хийдээс хлдон зүүн хойд зүгт замаа үргэлжлүүлсээр. Нам гүмд дассан гэлэнмаа нар огтын чимээ гаргалгүй явах бөгөөд гагцхүү хувцасных нь шор шорхийн шажигнах, хаа нэг чап пад хийн мөчир хугарах чимээ, улам өндөрт авирах тусам аахилан амьсгаадах дуу сонсогдоно.

Тэд Гуадарралийн уулын тэгш тал хүрээд хоёр захаар нь чулуун хана үргэлжлэх хөдөөх замаар орон хонь бэлчиж буй талбайн дэргэдүүр гарч, үүр цайхын үед Вильякастин хэмээх жижигхэн хотоос холгүй орших ойн цоорхойд ирлээ.

“Энд л би эднээс ангижрах юм шүү. Хойшид бурхан нь эднийгээ халамжлана биз ээ. Бурхан миний тухайд санаа тавьдгаа тавьж бид оргож чадлаа. Одоо хар толгойгоо бодож Швейцарь орохыгоо хичээх минь. Ганц сохор зоос ч үгүй, паспорт ч үгүй, тэгээд бас дээр нь гашуудлын өмсгөлтэйг яана. Бидний зугтсан тухай хийдэд довтолсон дээрэмчид аль хэдийнэ мэдсэн байгаа. Тэд биднийг олон олтлоо хайх болно. Энэ гэлэнмаа нараас хурдан салах тусам бидэнд сайнсан” гэж Лючия бодлоо.

Яг энэ мөчид бүсгүйн төлөвлөгөөг өөрчлөхөд хүргэсэн нэгэн хачирхалтай

явдал боллоо.

Гэлэнмаа Тереза мөчир доогуур шурган явж байснаа гэнэт бүдрэн, оргож

боссон цагаасаа хойш элгэндээ болгоомжтой гэгч нь тэвэрч явсан

баадантай юм нь газарт унан, ёрог даавуун боодол нь задарч нөгөө юм нь

гулсан ойчлоо. Гайхаж хоцорсон Лючиягийн өмнө том гэгчийн уран хийцтэй, алтан загалмай мандах нарны туяанд хорхой хүрэм гялалзан харагдах нь

тэр ээ.

“Энэ чинь цэвэр алт байна. Дээд бурхан миний төлөө санаа тавихаа шийдэв

боллолтой. Энэ загалмай ч ёстой нэг тэнгэрийн хишиг байна даа. Жинхэнэ

тэнгэрийн хишиг шүү. Энэ чинь яг л Швейцарь орох миний тасалбар мөн дөө

хөөрхий”.

Тереза гэлэнмаа алтан загалмайг аван ёрог даавуунд болгоомжтой гэгч нь

баадагнаж байхыг ажиглан, үүнийг гартаа оруулна гэдэг түүнд алга

урвуулахын төдий амархан болохыг төсөөлөн Лючия дотроо таатайяа

инээв. Энэ гэлэнмаа нар түүний хэлсэн болгоныг хийх болно оо.

###

Авила хот тэр чигээрээ үймэлдцэгээнэ. Хийдэд халдан довтолсон мэдээ хот

даяар тархаж, арга мухардсан хийдийнхэн Беррендо гэгээнтнийг Акока

хурандаатай уулзуулахаар томилжээ. Гэгээнтэн дал шүргэж яваа агаад

түүний дорой мэт үзэгдэх хуурмаг гадаад төрх нь ер бусын эрч хүчийг нь

далдлан нуух ажээ.

Ламтан өөрийн үнэнч шүтлэгтнүүддээ цагаан санаа, өр нимгэнтэй гэгээнтэн

харагддаг бол одоо тэр шударга зэвүүцэлд авгжээ.

Гэгээнтнийг хурандаа Акокагийн гэгээн дүрийг харах хүртэл үүдний танхимд цаг шахам суулган чилээжээ.

-Та өчүүхэн төдий шалтгаанаар шалтаглаж өөрийн хүмүүсийн хамтаар хийд рүү халдан довтолсон байна. Энэ бол цэвэр бодлогогүй явдал хэмээн Беррендо ямар ч оршилгүй шууд эхлэхэд,

-Бид зөвхөн үүргээ л биелүүлсэн. Хайме Миро өөрийн алуурчин дээрэмчдийн хамтаар хийдэд нуугдаж байсан болохоор гэлэнмаа нар өөрсдөө буруутай. Бид тэднийг байцаахаар л баривчилсан юм хэмээн хурандаа ажиг ч үгүй хариулав.

-Тэгээд та нар гэлэнмаа нарын хийдээс Хайме Мируг олоо юу? гэж гэгээнтэн уурсан асуусанд,

-Үгүй. Тэр хүмүүсийнхээ хамтаар биднийг очихоосөмнө амжиж нуугдсан

байна лээ. Гэсэн ч бид тэнийг олохдоо л олж, цээрлүүлэх болно гэж хурандаа тайван хариулав.

“Би заавал ч үгүй цээрлүүлэх болно” хэмээн хурандаа хорсон боджээ.

БҮЛЭГ 5

Гэлэнмаа нар тушаатай галуу л ингэж явдаг болов уу гэлтэй явж цөхнө.

Үнэндээ ч тэдний өмсгөл бартаатай газраар зугаалахад тийм ч зохимжтой

бус бөгөөд сандаалных нь нимгэн ул хад чулуунаас хамгаалж чадахгүй

хайрга хад улнаас нь хатгаж, шархадсан элээ шиг салбагар хувцас нь

модны мөчир, хадны ирмэгт тээглэж гацах нь гачлантай. Тэр ч бүү хэл,

Тереза гэлэнмаа залбирч ч чадахгүй, нүүр амаа модны мөчирт

шавхуурдуулахгүй гэсэндээ үргэлж мөчиртэй ноцолдож, маажигнан явав.

Аргагүйн эрхэнд олдсон эрх чөлөө нь гэгээн цагаан өдрийн цагаар тэдэнд

бүр ч аюултай мэт санагдана.

Бурхан эгч дүү дөрвөн гэлэнмааг өөрийн мэдлийн энхжингийн орноос хөөн, тэднийг ивээлээсээ хасаж, өчнөөн жил толгой хоргодох найдварыг нь

тасалжээ. Тэд гэнэт зүг чиг заагч луужин ч үгүй, газрын зураг ч үгүй үл

мэдэгдэх ертөнцөд ирчихжээ. Зовлон, золгүй явдлын хаалт болж байсан

хийдийн туурга нь үгүй болж, гэлэнмаа нар ёстой л нэг үнсэнд хаясан шалз

шиг орхигдсон мэт санагдана. Хаа сайгүй аюул нүүрлэж, тэд хойшид толгой

хоргодох газаргүй нөмгөн хоцрох нь тэр ээ.

Дасаж дадаагүй хорвоогийн дүр зураг, дуу авиа, аж амьдрал нь тэднийг

цочирдуулах аж. Гэлэнмаа нар амьдралдаа анх удаа шавьж, халуу оргисон

хөх тэнгэрийн харж, шувуудын жиргээг сонсохын зэрэгцээгээр бас нэг юм

тэдний сэтгэлийг зовооно. Тереза, Грасиела, Миган гурав эхэн үедээ хийдийн туурга дотор байгаа мэт санан заншсан ёсоор бие биесийг харахаас ч зайлсхийж байсан бол харин одоо хэн нь ч эмэгтэй хүний сониуч зангаар бие биенийхээ царайг ажиглаж эхэлжээ. Басхүү өчнөөн олон жилийн турш дуугүй байсны эцэст ярихаа бараг мартаж шахсан тул түгдрэн ээрч, муурч гацаж цоо шинэ, үл мэдэгдэх зүйлийг эзэмдэж байгаа мэт тэдний яриа нэг л итгэлгүйхэн санагдана. Гэлэнмаа нар өөрсдийн дуу хоолойг ч таньсангүй.

Ганцхан Лючияд юу ч эс саад болон тэрээр өөртөө итгэл төгс байгаа тул гэлэнмаа нар өөрийн эрхгүй түүнд захирагдах ажээ.

-Бид танилццагаавал муугүй л байх даа. Би гэлэнмаа Лючия байна гэж бүсгүйг хэлбэл самгардсаны эцэст,

-Би гэлэнмаа Грасиела байна хэмээн Грасиела хулгасхийн өөрийгөө танилцуулав.

“Хар үстэй, гайхмаар үзэсгэлэнт бүсгүй”.

-Би гэлэнмаа Миган гэлээ.

“Сүрхий цэнхэр нүдтэй, цайвар үст залуухан бүсгүй”.

-Би гэлэнмаа Тереза байна.

“Биднээс хамгийн ахмад нь аж. Тэр хэдтэй юм бол? Тавьтай юу? Жар хүрсэн юм болов уу?”.

Тэд тосгоноос холгүйхэн ойд хэвтэн амарцгааж байхдаа Лючия “Тэд яг л үүрнээсээ унасан ангаахайнууд шиг арчаагүй байх юм. Эд амиа тээж явцгааж чадахгүй нь ээ. Эд нар ч баларч гүйцэх бий вий. Гэвч яа гэх вэ дээ. Харин би загалмайг аваад Швейцарийг зорино доо” хэмээн бодож хэвтэв. Лючия амарч хэвтэж байсан ойн зах руу очиж модны сиймхийгээр харвал ойн доохно талд жижигхэн хот харагдаж, гудамжаар нь хүмүүс явж үзэгдэх авч, хийд рүү довтолсон этгээдүүд тэдний дунд үзэгдсэнгүй.

Лючия боломжийг алдаж болохгүй хэмээн шийджээ.

Бүсгүй бусад дээрээ эргэж ирээд,

-Би хот орж идэх юм олж ирэхийг бодье. Харин та нар эндээ хүлээж бай гэснээ Тереза тийш дохин,

-Та надтай хамт яв гэж нэмж хэлэв.

Гэлэнмаа Тереза чамгүй сандарчээ.

Тэрээр гучин жилийн турш ширээт гэлэнмаа Бетины зааврыг биелүүлж байсан бол одоо гэнэт энэ гэлэнмаад захирагдах болох нь. “Яадаг ч байсан

бүх юм бурханы тааллаар болдогсон доо. Бурхан бидэнд туслуулахаар

Лючия гэлэнмааг илгээж, бурхан түүгэр дамжуулж бидэнтэй ярьж байна”

хэмээн наминчлан боджээ.

-Би энэ загалмайг аль болох хурдхан ш иг Мендавын хийдэд өгөх ёстой

юмсан гэхэд нь,

-Тэгэлгүй яах вэ, бид хот орж хаашаа явах ёстойгоо асууж авна гэж Лючия

итгэл төгс хариулав.

Ингээд тэр хоёр хот чиглэн уулнаас буув.

Лючия өчүүхэн төдий ч болов аюул ослыг анзааралгүй өнгөрөөх вий

гэсэндээ ийш тийшээ хянамгай гэгч нь ажиглан явав. Гэвч эргэн тойронд

нам тайван байсанд “Ямар ч төвөг алга” хэмээн бодов.

Тэд явсаар “Вильякастин” хэмээх таних тэмдэг бүхий хотын захад ирэхэд

зүүн талд нь хүн амьтангүй нарийн гудамж залгасан хотын төв гудамж

харагдав.

“Ашгай юу даа, одоо болох явдлыг харах хүн алга” гэж Лючия бодоод нарийн гудам руу эргэн,

-Ийшээ явцгаая. Бид энд хүний нүдэнд өртөх нь бага бололтой гэлээ.

Тереза гэлэнмаа толгой дохиод, түүний араас дуулгавартай дагалаа. Одоо түүний гараас загалмайг булааж авах л үлдлээ.

“Би загалмайг шүүрч аваад зугтчихаж чадна даа, гэтэл тэр хашхирч гуугачаад олны анхаарлыг татчихна. Үгүй ээ, бодох хэрэгтэй. Хэрхэн нам тайван хийхийг бодох хэрэгтэй”.

Түүний өмнө газарт унасан яргай гишүү хэвтэж байхыг хараад тонгойн авлаа. Дажгүй хүнд юмаа. “Сайхаан, сайхан”. Тэрээр Терезаг хүлээн зогсосхийв.

-Тереза эгч ээ.

Гэлэнмаа түүнд дөхөж ирээд, түүн рүү эгцлэн харах тэрхэн агшинд Лючия яргай гишүүгээ далайхаар зэхтэл хаа нэгтэйгээс эр хүний дуу гарч,

-Бурхан та нарыг ивээг, эгч дүүс минь! гэх нь сонсогдох нь тэр.

Лючия зугтахаар бэлтгэн огцом эргэн харвал түүний өмнө хүрэн өнгийн урт өмсгөл өмссөн, юүдэнг нь угласан нэг лам зогсож байлаа. Тэрээр өндөр нуруутай, эцэнхий нэгэн байх агаад бүргэд хамарласан түүний царайд гэм хоргүй хутагтын дүр тодорч, нүднээс нь уян дулаан гэрэл цацарч, намуухан эелдэг дуугаар ярих ажээ.

-Би Мигель Каррильо лам байна.

Лючиягийн эхний төлөвлөгөө нурсан ч гэлээ тархи нь гэрлийн хурдаар ажиллаж санамсаргүй байтал өөр нэгэн дөнгүүр төлөвлөгөө толгойд нь орж

ирлээ.

-Бурханы авралаар бид тангай учирлаа хэмээн Лючия өгүүлэв.

Энэ хүн түүнийг нуугдахад тусалж, Испаниас гарах хялбар замыг зааж өгөх болно.

-Бид Авилагаас холгүй орших хийдийнхэн. Өнгөрсөн шөнө манай хийд рүү ямарыг нь мэдэхгүй хэдэн хүмүүс уулгалан дайрч, бүх гэлэнмаануудыг баривчлаад авч явсан. Бид дөрвүүлээ зугтааж чадлаа.

Лам эр илт зэвүүцсэн өнгөөр,

-Би сүүлийн хорь шахам жилийг Сан-Хенерро хийдэд шавиллаа. Уржигдар шөнө бид довтолгоонд өртсөн дөө гээд уртаар шүүрс алдаж,

-Бурханы мунхаг шүтлэгтэн бидний хувь заяа түүний гэгээн мутарт байдаг атал дээд гэгээн бурхан минь энэ удаад бидэнд ямар шуу зам мөр зааж өгснийг үнэндээ хэлж мэдэхгүй нь ээ гэлээ.

-Тэр хүмүүс биднийг хайж байгаа. Бид даруйхан аль болох түргэхэн шиг

Испаниас гарах хэрэгтэй байна. яаж гарахыг минь та мэдэж байна уу? гэж

Лючия асуулаа.

-Эгч дүүс минь, би та нарт тусалж дөнгөнө гэж бодох юм. Бурхан биднийг учруулжээ. Намайг бусад дээрээ дагуулаад оч гэж Каррильо ламтан хариулав.

Хэдэн минутын дараа гэхэд Лючия ламтанг дагуулсаар үлдсэн гэлэнмаа нар дээрээ очоод,

-Энэ Каррильо ламтан. Тэрээр хорин жил хийдэд шавилсан гэнэ. Тэр бидэнд туслахаар ирлээ хэмээн түүнийг танилцуулав.

Гэлэнмаа нар ламтны айлчлалыг янз янзаар хүлээн авчээ. Грасиела түүн тийш харц өргөн харахаас хулгасхийж байсан бол Миган сониучирхан ширтэж, харин Тереза өөрсдийг нь Мендав хийдэд хүргэх өгөхөд туслах бурханы элч мэт хандаж байжээ.

-Хийдэд халдсан этгээдүүд та нарыг хайж байгаа нь гарцаагүй. Тэд дөрвөн гэлэнмаа хайж байгаа болохоор та нар юутай ч болов хувцсаа солих хэрэгтэй гэж Каррильо ламтан айлдав.

-Бид нарт өмсөх юм алга гэж Миганыг хэлэхэд,

-Бурханы мэдэлд олон хувцас бий. Санаа бүү зов, хүү минь. Тэр туслахдаа л тусална. Хот руу буцаж очье гэж лам Каррильо хэлжээ.

Үдийн хоёр цаг болчихсон Испани, Латин Америкийн орнуудад хамгийн халуун улиралд үдээс хойш удтал амардаг үе байлаа.

Каррильо дөрвөн гэлэнмааг дагуулан хотын төв гудамжаар орон, элдэн хөөх анхны сэжиг төрмөгц тэдэнд нуугдахад нь туслахад бэлэн гэтэх нь шахуу

гэлдэрнэ. Дэлгүүр хоршоо хаачихсан, харин баар ресторана ажиллаж,

тэндээс чих дөжрөм чангаар үл таних хөгжим хангинана.

Каррильо ламтан Тереза гэлэнмаагийн царайг хараад,

-Энэ чинь рок-н-ролл хөгжим. Одоогийн залуусын дунд их алдартай болоод байгаа юм хэмээв.

Нэгэн баарны дэргэд зогсох хоёр эмэгтэй өмнүүр нь явж өнгөрөх гэлэнмаа нарыг хайхрамжгүй харахад гэлэнмаа нар тэдний хачин өмсгөлийг нүд нь орой дээрээ гарах шахам гайхан ширтэх ажээ. Тэдний нэг нь төө хүрэхтэй үгүйтэй өгзгийг нь дөнгөж халхлах төдийхөн банзлын тасархайтай, нөгөөх нь ташаандаа тултал ухлаадастай гуя хас нь гялалзсан урт гэгчийн банзал углажээ. Хоёр бүсгүй цээжин биеийг нь чавхайтал барьсан ханцуйгүй даавуун майк өмссөн байв.

“Тэд бараг шалдан байх чинь” хэмээн Тереза аягүйцэн бодлоо.

Үүдний дэргэд өндөр хүзүүтэй цамц, захгүй хачин загварын пиджак, хүзүүндээ зүүлт бүхий нэгэн эр зогсох ажээ. Виски тамхины эхүүн үнэр гэлэнмаа нарт ханхийн үнэртэв. Миган гэнэт эсрэг талын гудамж тийш хараад ***** гадас шиг дороо зогсчихлоо.

-Яасан бэ? Юу болов? гэж Каррильо ламтан айдаст авган гайхан асуулаа.

Миган хүүхэд тэвэрсэн бүсгүйг цоо ширтэн зогсож байжээ. Сүүлчийн удаа нялх хүүхэд харсан тэр цагаас хойш хэчнээн ч хугацаа өнгөрөө вэ. Тэрээр нялх хүүхдийг тэртээ 14 жилийн өмнө асрамжийн газар харсан сан.

Миган гэнэт сэтгэл догдолсноо, тэрээр орчлонгийн амьдралаас хэчнээн их тасарснаа ойлгосон байна.

Гэлэнмаа Тереза хүүхдийг хараад “Энэ бяцхан Моник байна”. Гудамжны эсрэг талаас хүүхдийн уйлах дуу сонсогдоход “Би түүнийг гудамжинд шахуу орхисон болохоор тэр уйлж байна. үгүй ээ, тийм байх ёсгүй. Тэр цагаас хойш 30 жил өнгөрсөн шүү дээ”. Тереза гэлэнмаа буруу харсан ч чихэнд нь хүүхдийн уйлах дуу хангинасаар байлаа. Чингээд гэлэнмаа нар цааш хөдөлцгөөв.

Тэднийг театрын дэргэдүүр өнгөрөхөд “Гурван амраг” гэсэн хагас шалдан хүүхэн нүцгэн эрийн бүсэлхийгээр тэвэрсэн зураг бүхий зарлал харагдлаа.

-Бурхан минь! Эд чинь чармай шалдан байх чинь! гэж Тереза гэлэнмаа дуу алдлаа.

Каррильо ламтан царайгаа барайлган,

-Энэ чинь жинхэнэ порно кино. Кино театруудад үүнийг үзүүлэхийг зөвшөөрч байгаа нь тун хачирхалтай. Дотно сэтгэлийн хамгийн нандин бүхнийг түмний

нүдэн дээр гаргаж байдаг. Ингэснээрээ томчуул хүүхдийг араатан болгож

байгаа хэрэг хэмээн унтууцав.

Тэд цаашлан бараан дэлгүүр, үсчин, цэцгийн дэлгүүр, хүнсний дэлгүүрийн

дэргэдүүр явтал амралтын цаг гээд бүгд хаалттай байгаа агаад гэлэнмаа

нар эд бараагаар дүүрэн үзмэрийн дэргэд зогсон лангууг нүд бэлчээн харан

ангайцгаав.

Тэд эмэгтэй хүний хувцасны дэлгүүрт дөхөж очоод Каррильо тэднийг

зогсоон,

-Намайг эндээ хүлээж бай гэв.

Дөрвөн эмэгтэй түүнийг булан тойрон далд орохыг нь харсаар хоцорч,

эргэлзсэн янзтай харц солилцлоо. Тэрээр хаачих нь юм бол оо, эргэж ирэх л

байгаа даа?

Хэдхэн минутын дараа тэр дэлгүүрийн үүд торхийн нээгдэж, босгон дээр нь

Каррильо ламтан инээд алдан тэднийг орохыг урин,

-Алив түргэлээрэй хэмээн зогсож байх үзэгдэв.

Гэлэнмаа нар дэлгүүрт ормогц ламтан үүдийг хаангуут,

-Та яаж чадав аа? Гэж Лючияг асуухад,

-Бурхан нэвтэрч орох хаалга бүтээсэн байдаг юм гэж ламтан нухацтай

өгүүлэв. Гэвч түүний хоолойд Миганы инээдийг өөрийн эрхгүй хүргэсэн

дүрсгүй нэгэн зан төрх тодорчээ.

Гэлэнмаа нар эрээн мяраан палааж, хүзүүтэй цамц, хөхний даруулга, оймс, өндөр өсгийтэй гутал гээд олон жилийн турш үзээгүй далай мэт баян

дэлгүүрийн бараанд сэтгэл татагдцагаах шиг нүд алдан ийш тийш

ширтэцгээв. Барааных нь донж маяг ч гэж ер бусын ажээ. Дэлгүүрт түрийвч, хүзүүний ороолт, энгэсэгний сав, гадуур хувцас пиг дүүрэн байв.

Бүсгүйчүүл гайхширч хоцорчээ.

-Бид яаравчлах хэрэгтэй гэж Каррильо ламтан өөрийнх нь байгааг

мартсаныг гэлэнмаа нарт сануулах гэсэн мэт ам нээн хэлээд,

-Амралтын цаг дуусч, дэлгүүр онгойхоос өмнө бид эндээс явах ёстой. Таарч

тохирох хувцсаа сонгоцгоо гэлээ.

“Бурханы авралаас би дахин эмэгтэй хүн шиг хувцаслах нь дээ” гэж Лючия

бодоод палааж өлгөсөн лангуу тийш очин, хул өнгийн банзал, өнгө

хоршуулан хүрэн өнгийн цамц, дотоож, хөхний даруулга, зөөлөн шаахай

сонгосны дээр хувас солих бүхээгт орон хэдэн минутын дараа гэхэд бүрэн

хувцаслаж, явахад бэлэн болчихсон гарч ирлээ.

Бусад гэлэнмаа нар хувцсаа сонгох гэж нэлээд уджээ.

Грасиела хар үс, бор царайг нь улам тод болгосон хөвөн даавуу цагаан

палааж өмсөж, сандаал жийжээ.

Миган өвдөгнөөс үл ялиг доогуур зураг хуартай цэнхэр палааж өмсөж,
намхан өсгийтэй туфль углажээ.

Харин Тереза гэлэнмаад бусдаасаа хэцүү байгаа бололтой нүд эрээлжлэм
эрээн алаг, элбэг дэлбэг дэлгүүр түүнийг гайхшруулж орхижээ. Эргэн тойрон
торго, үслэг эд, арьс, судалтай, шоотой, өнгө өнгийн цэцэгтэй эд бөсөөр
хийсэн хувцас өлгөөтэй байх боловч бүгд хамгийн түрүүнд түүний санаанд
орж ирснээр бүх хувцаснуудад “оготор” гэсэн үг л таарах юм шиг санагдана.
Сүүлийн 30 жилийн туршид тэрээр нос ёсны дагуу төлөв түвшин томоотой
явж, амьдралынх нь утга учир болсон бараа сүртэй нүсэр хувцсаа өмсжээ.
Гэтэл одоо түүнийг нь тайлуулан, энэ зохисгүй өмсгөлийг биед нь өлгөх
болох нь. Ингээд Тереза газар шүргэм урт банзал, урт ханцуй, босоо захтай
цамж хайж эхэллээ.

-Эгч дүүс минь түргэлж үз. Хувцсаа тайлаад сольж өмс гэж Каррильо ламтан

яаруулахад гэлэнмаа нар аягүйцэн харц солилцлоо.

-Өө, тэгэлгүй яах вэ. Би оффист ороод хүлээж байя гээд ламтан дэлгүүрийн гүн рүү далд орлоо.

Ламтан Каррильо оффист ороод сандал тавьж, дээр нь авирч гараад жижигхэн цонхоор хувцсаа тайчин буй гэлэнмаа нарыг хулгай нүдээ ажиглаж “За байз хө, эдний алинаас эхлэх вэ” гэж үзлсээ залгин харж зогсов.

Мигель Каррильо хулгайэ ажлаа арван настайгаасаа эхэлжээ. Байгаль түүний сонгосон мэргэжилд нэлж барамгүй тусламж үзүүлэх мэт түүнд буржгар цайвар үс, язгууртан маягийн царай заяасан аж. Тэрээр халаасны болон дэлгүүрээс аахар, шаахар хулгайгаар эхэлсэн бол насны эрхээр ажиллагааныхаа хүрээг тэлэн, согтуучуудыг тонох, баян эмэгтэйчүүдийг залилах болжээ. Өөрийн ер бусын сэтгэл татам төрхийнхөө ачаар чамгүй амжилт олж, улам илүү нарийн ухаан шаардсан луйвардах арга сэдэх болсон байна. Гэтэл эр нэг гэнэдэж, эрэг нэг нурах гэгчээр аз нь хэлтийсэн эрийн сүүлчийн санаа бүтэлгүйтсэн аж.

Каррильо зэлүүд орших нэгэн хийдээс сахил хүртээд, сүм дуганаар хэсэж хоног төөрүүлэн шөнийг өнгөрөөхийг гуйхад нь түүнд хэн ч татгалздаггүй байлаа.

Гэтэл аз нь харьж хоёр хоногийн өмнө Авилагаас холгүй орших Бехар хотын нэгэн хийдэд хоноглохоор тохирчихоод байж байтал гэгээнтэн санамсаргүй эргэн ирж луйварчин эр Мигель Каррильо үйлдэл дээрээ гардуулжээ.

Санаснаас хийдийн гэгээнтэн гартаа нэлээд бүлтэй эр байж таарч, эгшин

зуурын төдийд Каррильо шалан дээр тэнгэр харуулан унагаж, цагдаад өгнө хэмээн сүрдүүлж, сандарсан Каррильо бултах аврал эрэн ийш тийш хартал хажууханд нь шалан дэр унасан мөнгөн бариултай шилээвэр үзэгдэхэд шүүрэн авч гэгээнтний тархин дундуур дэлсээд авчээ. Шилээвэр дэндүү хүнд байсан уу, эсвэл гэгээнтний гавлын яс өндөг шиг хэврэг байв уу, гэгээнтэн үхэдхийн унав. Сандарч тэвдсэн Мигель Каррильо хэргийн газраас аль болох холдох гэсэн цорын ганц хүсэлд авган хөлийн хурд мэдэн харайлгаж гарчээ. Мань зугтсаа Авила хотод ирээд, хурандаа Акокагийн толгойлсон “ГОВ” хэмээх нууц байгууллага хийдэд халдсан тухай олны яриаг сонссон Каррильо дөрвөн оргодол гэлэнмаатай учруулсан хувь заяа нь энэ ажгуу.

Ийнхүү тэрээр гэлэнмаа нарын чармай нүцгэрсэн биеийг шүлэнгэтэн ширтэж, бие сэтгэлээ хангана хэмээн урьтан баярлаж, “Сайхан хэрэгтэй учрав бололтой. Хурандаа Акока нэгэнт энэ гэлэнмаа нарыг хайж байгаа

бол мань эр дориухан үнэ төлж таарна. Би эхлээд эднээр жаал зугаацаж аваад, хожим нь Акокад тушаана” хэмээн бодон жуумалзав.

Лючиягаас бусад эмэгтэйчүүд шав шалдан зогсоно. Каррильо шинэ дотуур хувцсыг эв хавгүйхэн өмсөх гэлэнмаа нарыг шүлсээ савируулан хоор горьдох нохой шиг гөлийн харна. Тэд хувцсаа эв хавгүйхэн барьж үзэн, дасаж дадаагүй цахилгаан товчтой дүй муутайхан ноцолдож, хэр чинээгээрээ яарах ажээ.

“Ажилдаа орох цаг боллоо” гээд Каррильо баярлан бодоод авирч гарсан сандлаасаа буун дэлгүүрийн заал руу орон, бүсгүйчүүлд дөхөж очоод сайшаах харцаар сонжин хараад,

-Тун гайхалтай ... Ямар ч хүн та нарыг гэлэнмаа байсан гэж хэлэхээргүй харагдаж байна. Би бас та нарт толгойгоо алчуураар ороочих гэж хэлмээр байна гэв.

Гэлэнмаа нар ч ивээлт эрийнхээ үгэнд орон алчуур сонгон авч, толгойдоо зангидахыг тэрээр харан зогслоо.

Мигель Каррилто эхний хүүхнээр Грасиелаг сонгожээ. Тэр бүсгүй эргэлзэх юмгүй түүний хэзээ ч юм учирч явсан хүүхнүүдээс хавьгүй царайлаг байлаа.

Бие хаа ч гэж ёстой ванлий, жинхэнэ дагина л гэсэн үг! “Тачаадсан эрийг хориглож болно гэсэн мунхаг бодол яаж байх болох вэ. Юу хийх ёстойг нь бүсгүйд заагаад өгөмз”.

-Та нар мэдээж өлссөн байх гээд тэрээр Лючия, Миган, тереза гуравт хандан хэлээд,

-Би та нарыг бидний дэргэдүүр нь явж өнгөрсөн цайна газарт очиж, тэндээ

биднийг очтол хүлээж бай гэж хэлмээр байна. Би хийд орж, гэгээнтнээс

бидэнд хүнс авах хэд гурван зоос гуйя гэснээ Грасиела руу эргэн,

-Харин гэлэнмаа та надтай цуг явж, хийдэд болсон явдлын тухай гэгээнтэнд айлтга гэлээ.

-Би ... за тэгье гэж Грасиела түгдчив.

-Бид удахгүй та нар дээр очимз. Арын хаалгаар гарсан нь дээр гэж зөвлөмөөр байна гэж Каррильо бусад гэлэнмаа нарт хэллээ.

Каррильо Лючия, Миган, Тереза гурвыг дэлгүүрээс гарч явахыг хүлээзнэж байгаад, хаалга хаагдахыг сонсмогц Грасиела руу эргэн “Энэ хүүхэн ямар үзэсгэлэнтэй юм бэ. Ер нь үүнийг авч яван, ажилдаа хамсуулж ч болох юм биш үү. Энэ ч давгүй тус болно шүү” хэмээн сүүрс алдав.

Грасиела түүн тийш эргэн,

-Би бэлэн гэв.

-Яг таг ч бэлэн биш байх шиг байна хэмээгээд Каррильо хувцсыг нь сонжин

буй дүр үзүүлэв.

-Үгүй ээ, энэ чинь тохирохгүй болов уу гэж би айж байна. Наад палааж чинь чамд таарахгүй дэг ээ. Тайл найдах аа! гэлээ.

-Яагаад?

-Чамд зохихгүй байна гэж тэр нүдээ үл цавчлан хэлээд,

-Чамайг тэр дор нь анзаарах болно, энэ чамд огт хамаагүй хэрэг юм шив гэлээ.

Бүсгүй түдгэлзэн өлгүүрт ийш аажмаар эргэлээ.

-Хурдалж үз, бидэнд цаг бага байна.

Грасиела баахан аягүйрхээд палаажаа дээш сөхөн тайллаа. Тэр зөвхөн дотоож, хөхний даруулгатай үлдэн шалдан шахуу байж байтал нь гэнэт

Каррильо сүүдэгнэн дөхөж ирээд,

-Бүгдийг нь тайл гэж сөөнгөтөн хэлэв.

Грасиела түүнийг нүд салгалгүй ширтэн,

-Юу? Үгүй ээ? Би ... би чадахгүй. Таныг гуйя ... Би ... гэлээ.

Каррильо улам ойртон,

-Би чамд туслая, эгч минь гээд дотуур хувцсыг нь хуу татахаар гараа сунгалаа.

-Үгүй ээ, бүү хүр. Болиоч!

Каррильо хөгцтэй шар шүдээ ярзайлган инээж,

-Хонгорхон минь, бид дөнгөж эхэлж байна. Энэ чамд таалагдаж болно гэлээ.

Тэрээр бахим гараараа тамир муутай бүсгүйг угз татан шалан дээр унагаад

урт хормойгоо огшоон дээш сөхлөө.

Хөшиг татчихав уу гэлтэй Грасиелагийн толгой манаран харанхуй оргиж эхэллээ. Энэ Мавр байна, тэр дахиад түүний биед шургаж орох нь, бүр хамгийн гүн рүү нь шүү. Тэрээр гэнэтхэн эхийнхээ чарлах дууг сонслоо. “Үгүй ээ, үүнийг л биш шүү. Хэрэггүй ..., үүнийг л биш ...” хэмээн айдаст автан бодлоо.

Бүсгүй уурсан эсэргүүцэж, тэмцэлдэж босохыг оролдов.

-Чамайг чөтгөр аваасай гэж мунаг эр хашхирав.

Хилэгнэн уурссан Каррильо нүүрэн дундуур нь дэлсээд авлаа. Грасиела дахин шалан дээр түсхийн унаж, нүднийх нь өмнүүр бүх юм эргэлдэн, тэрээр өнгөрсөн үе тийшээгээ хар хурдаараа эргэн очих шиг санагдав.

Өнгөрсөн тийш ... Гэдрэг буцлаа ...

БҮЛЭГ 6

Тэр таван настай байлаа. Түүний хамгийн эртний дурсамж нь эхийнх нь өвөрт ээлж ээлжээр солигдож байдаг үл таних олон нүцгэн эрчүүдтэй холбоотой.

-Эд нар чиний ах. Чи эдэнд найрсаг хандах ёстой хэмээн эх нь тайлбарлана.

Тэд бүгд бүдүүлэг, балиар бас нялуун шалиг зангаас уйдаггүй улс байлаа.

Долоо хоног, сар шахам шахам хоног төөрүүлж байснаа эцэст нь бараа туруугүй алга болцгооход нь Долорес Пиньеро өөр эрийн эрэлд морддог байжээ.

Долорес Пиньеро залуудаа нүд булаасан үзэсгэлэнт бүсгүй байсан агаад Грасиела эхийнхээ гадаад төрхийг өвлөн авчээ. Грасиела бүсгүй бүр хүүхэд байхдаа л өндөр шанаа, өөгүй бор царай, гялалзсан хар үс, өтгөн урт сормуустай өөрийнхөө үзэсгэлэнтэй болохыг анзаарчээ. Тэр үед л тэгш сайхан бие хаа нь бүр ч илүү сэтгэл татам болохыг хэлж байжээ.

Жил ирэх тусам Долорес Пиньеро мариалан бүдүүрч, үл мэдэгдэн өнгөрөх цаг хугацаа түүний урьдын сайхан царайг гундааж эхэлсэн хэдий ч тэр хуучин янзаараа боломжийн тачаангуй амраг хэмээн цуутай болжээ.

Янагийн ажил бүсгүйн амжилт олдог цорын ганц хөдөлмөр бөгөөд үүнийгээ ашиглан тэрээр эрчүүдийг худалдан авч өөртөө татахыг оролдон тэднийг аргадан долигононо. Тэрээр хэр тааруу эзэмшсэн оёдолчны мэргэжлээрээ амьдралаа дөнгөн данган өл залгуулах агаад түүний үйлчлүүлэгчид дөнгүүрийг худалдан авчих тэнхэлгүй ядруухан эмэгтэйчүүд байдаг ажээ.

Долорес Пиньеро хэзээ ч хайрлаж байгаагүй цорын ганц хүнийг үргэлж

санагдуулдаг болохоор охиндоо тун ширүүн хандан, нүд үзүүрлэдэг байв.

Грасиелын эцэг үзэсгэлэнт хүүхэн Долорест сэтгэл алдарсан сайхан залуу механикч эр байсан бөгөөд Долорес ч түүнийг дуртайяа таалсан сан. Харин бүсгүйг жирэмсэн болсноо дуулгамагц мань эр нүүр буруулан Долорест үр удмыг нь өширхөн хорсуулах сэтгэл тээлгэн арилаад өгчээ.

Долорес олхиогүй зан гарган, өш хонзонгоо өөдсөн чинээ хүүхдэд гаргах нь тамтай. Грасиелаг сэтгэлд үл нийцэх юм хийх аваас эх нь “Чи яг эцэг шигээ мулгуу амьтан” гэж хараал урсган бархирч гардаг байв.

Бяцхан охин байнгын зодуур, үргэлжийн хашхичин загнахаас зайлах газар үгүй, нүхээ алдсан оготно мэт бүлтгэнэнэ.

Грасиела өглөө сэрэнгүүтээ л “Бурхан минь, намайг өнөөдөр ээжид зодуулахгүй байхыг чамаас гуйя. Бурхан минь, ээжийг минь надад хайртай гэж хэлэхийг ямар их хүсч байна гээч” хэмээн залбирч өдрийг угтдаг байжээ.

Эх нь Грасиелаг загнаж зандрахгүй үедээ түүнийг хүн чинээ бодохгүй үл анзаарах тул тэрээр хоол хүнсээ өөрөө бэлтгэж, хувцас хунараа цэвэрлэж базаана. Охин бэлтгэсэн үдийн хоолоо сургууль руугаа авч очин “Ээж өнөөдөр надад хуушуур хайрч өгсөн. Ээж минь намайг махтай хуушууранд дуртайг мэднэ л дээ” эсвэл “Би палаажаа урчихсан чинь ээж оёж өгсөн. Ээж минь миний төлөө бүхнийг хийдэг юм” гэх юм уу “Маргааш ээж бид хоёр кино үзнэ” хэмээн багшдаа сайрхан ярьдаг байж.

Гэсэн ч охиныг өрөвдсөндөө багшийн зүрх зүсэгдэх шиг болдог байв. Лас-Навас-дель-Маркес нь Авилагаас цаг шахам явах зайтай оршдог бөгөөд юу ч болно тэр даруй хот даяар тархан бүгдийнх нь сонорыг мялаачихдаг бусад жижиг хотуудын адил жирийн л нэг жижигхэн хот байлаа. Долорес Пиньерогийн амьдралын хэв маягийг бүх нийтээр шүүмжлэн буруушаах тул айлын эзэгтэй нар өөрийн үр хүүхдээ муу үлгэр дуурайл авчихна гээд Грасиелатай тоглохыг зөвшөөрдөггүй ажээ. Грасиела Дель Кристод байрлах сургуульд явдаг бөгөөд түүнд нэг дотнын найз, найз охин байдаггүй байжээ. Тэр нэлээд авьяаслаг сурагчдын нэг байсан мөртлөө үргэлж өөрийгөө ядарсан мэт бодох охин анхаарлаа төвлөрүүлж чадахгүй муу дүнгээс салдаггүй байсан ажээ.

“Грасиела чи эрт унтах ёстой. Гэрийн даалгавраа сайн хийхийн тулд чамд бүрэн амрах тун чухал шүү” гэж багш нь охинд зөвлөнө.

Гэвч түүний ядраад байгаагийн шалтгаан нь орой унтсандаа биш ээ.

Грасиела эхийнхээ хамт хоёр өрөө жижиг байранд амьдрах бөгөөд эхийнхээ унтлагын өрөөнөөс хуучин муу хөшгөөр тусгаарлах төдийхнөөр оромдсон

жижиг буланд буйдан дээр унтдаг агаад Грасиелаг шөнө дунд сэрээдэг тэр гэхийн тэмдэггүй гийнан яраглах, уухилж аахилан амьсгаадах, ёсгүй авирлах дуу чимээний тухай багшдаа хэрхэн хэлэх билээ. Охин цочин сэрэнгээ эх нь өвөртөлсөн ээлжит эртэйгээ хэрхэн загас наадуулж байгааг сонсон удтал сэрүүн хэвтдэг байжээ.

Грасиела дүнгийн хүснэгтээ авчрахад эх нь үзээд “Чамайг иймэрхүү дүн авчрана гэдгийг би мэдээд байсан юм аа. Яагаад чи муу дүн авч байгаагаа мэдэж байна уу. Яагаад гэвэл чи маанаг гайхал. Мулгуу амьтан” гэж хашхичиж эхлэхэд охин эхийнхээ хэлсэн үгэнд итгэн, хамаг чадлаа шавхан нулимсаа тэвчдэг байлаа.

Грасиела хичээлийн дараагаар гэр бүлээ хайрлан халамжилж амьдардаг өмнүүр нь хуайс мод ургасан цав цагаан байшингууд бүхий муруй сарий гудамжаар орь ганцаар хэсүүчлэн сэлгүүцэх эрх чөлөөг өөрөө өөртөө олгодог байв.

Грасиела мөрөөдөн бодохдоо, олон найзтай, түүний бодлоор найз нар нь сайхан охид хөвгүүд, түүнийг баяртай урин дайлж цайлдаг, тэд нар охиныг ухаантай, сайн хэмээн тооцож, эелдэг харьцаж, Грасиела эхийнхээ эзгүйд тэдэнтэйгээ удтал ярьж хөөрөн сэтгэл тэнүүн байгаагаар төсөөлнө. Мөн, “Грасиела чи надад гэрийн даалгавраа хийхэд туслахгүй юу? Би бодлогоо бодож чадахгүй байна, чи сайн боддог ш дээ”.

“Грасиела орой юу хийцгээх вэ? Хамт кино үзэж, хотоор зугаалж, кока кола ууж ч болох юм”.

“Грасиела! Ээж чинь чамайг манайх руу хонуулахаар явуулах болов уу? Манайх плов хийнэ гэсэн”.

“Ээж маань намайг явуулахгүй байх аа. Надгүйгээр тэр үргэлж ганцаарддаг юм. Түүнд надаас өөр хэн ч байхгүй шүү дээ” хэмээн ганцаараа ярьдаг байжээ.

Ням гаригийн өглөө бүр Грасиела эртлэн босч, эхийгээ болон өвөрт нь хэвтэх ахыг сэрээхгүйн тулд хулгана мэт чимээгүйхэн хувцаслаад, гэгээн эцэг Пересийн үхлийн дараах амьдралын баяр баясгалан, үлгэрийн мэт бурханы орны амьдралын тухай номлодог хийд рүү очин наминчлан бяцхан зүрхэндээ бушуухан үхэж бурхантай учрахыг хүсэх болжээ.

Гэгээн эцэг Перес дөч шүргэж яваа, нүдэнд дулаахан нэгэн байлаа. Тэрээр нэлээд хэдэн жилийн өмнө Лас-Навас-дель-Маркест ирсэн агаад баян, ядуу өвчинд нэрвэгдсэн, шаналсан, эрүүл цовоо хэн бүхэнтэй адил тэгш дотно харьцаж, хотод түүний сонорт хүрч, ивээлд нь ороогүй нууц гэж үгүй болжээ.

Перес ламтан Грасиелаг хийдэд байнга ирэхийг нь харж, тэр Долорес

Пенерьогийн тоолж барамгүй дурлалтангуудын тухай хэдийнээс мэдэх

болсон. Ийм нөхцөл байдал охинд тэсвэрлэхийн аргагүй хүнд байгаа, гэхдээ

хэн түүнд туслах вэ? Гэгээнтэн, Грасиелагийн хачин эелдэг, өр нимгэнтэй, өөрийн амьдралдаа хэзээ ч гомдоллохгүй өсч буйд нь үнэнхүү гайхна.

Ням гаригийн өглөө бүр Грасиела хийдэд ирэхдээ цэвэр цэмцгэр хувцаслах

агаад ламтан түүнийг охин өөрөө угааж, цэвэрлэсэн гэдэгт үл эргэлзэнэ.

Перес ламтан хотын хүүхэд болгон шахуу Грасиелагаас нүүр буруулан

зугтааж байгааг мэдрэн охиныг үнэн сэтгэлээсээ өрөвдөнө. Ням гариг бүрт

ламтан уншлаа номоо өндөрлөсний хойно багахан шиг боловч цагийг охинд

зориулдаг бөгөөд зав муутай үедээ зайрмагаар дайлахаар кафед дагуулан

ордог байлаа.

Өвлийн цагт Грасиелагийн амьдрал бүр ч уйтгартай нэг л хэвийн бүүдгэр

санагдана. Лас-Навас-дель-Маркес эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн

хөндийд орших тул эндхийн өвөл зургаан сар шахам үргэлжилнэ.

Зун нь бол хот олон зочин, жуулчнаар дүүрч, хаа сайгүй баяр баясгалан, зугуу цэнгэлээр бялхан амилах мэт болдог. Жуулчид Мануель Дельгада

Баредогийн талбай дахь бага шиг тайзны дэргэд овоорон хөл нүцгэн хотын оршин суугчид гар гараасаа барилцан тойрог болж, эртний каталон ардын бүжгийг гунхан хийхийг харж зогсоно. Грасиела гудамжинд тухлан суух, загасны захаар хэсүүчлэх, эмийн сангаар холхих жуулчдыг харах дуртай.

Үдийн цайны үеэр дарсны мухлаг жуулчдаар хахаж, дарсыг наймаалж, шарсан төмсөөр даруулан тухлан сууцгаадаг байлаа.

Харин Грасиелад хотын төв гудамжаар бөөн бөөнөөрөө зугаалах залуучууд охидыг нүд эргүүлдэн ширтэж, энэ үеэр эцэг, эх, эмээ, өвөө нар нь тэдний араас сэрэмжлэн мөрдөж, гудамжны кафед хялалзан суухыг харах дуртай байв. Энэ нь уламжлалт үзвэртэй зүйрлэхийн аргагүй туйлын сонирхолтой мөнхийн ёслол болдог ажээ. Грасиела энэхүү ёслолд оролцохыг ихэд хүсэх авч эх нь түүнийг эрс хориглон “Чи чинь янхан болохыг хүсээ юу? Банди нараас холхон явж бай. Тэдэнд чамаас ганцхан юм л хэрэгтэй. Би үүнийг махан биеэрээ амссан туршлагаа мэдэж байна” гэж хашхичин байж хэлнэ.

Өдөр харвасан сум мэт үл анзаарагдам өнгөрч тарчилгаант шөнө эхлэхэд, нимгэн хөшгөөр тусгаарлагдсан эхийнх нь орноос араатны мэт ёолон архирах, уухилан амьсгаадах, зогсоо зайгүй зохисгүй авиа сонсогдоно.

“Хурдан, хурдан ... лавхан шургуул!”

“Содете!”

“Matate el yerda”

“Melelo en e! silo”

Грасиела арван нас ч хүрээгүй байхдаа испани хэлний ёозгүй үг хэллэгийг бүгдийг мэддэг болсон байв. Тэд шивнэн ярьж, хоолой нь чичигнэж, ёолон дуу алдацгаана. Тачаадан орилох дуу нь Грасиелаг зэвүүцэх, басхүү үл мэдэх шаналгааг төрүүлнэ.

Мавр гэгч эр Грасиелаг арван дөрөвтэй байхад тэднийд үзэгджээ. Охин түүн шиг үлэмж биетнийг урьд өмнө нь хэзээ ч харж байгаагүй. Тэрээр тос даасан гялалзсан хар арьстай, толгой нь мулзан, бахим ханхар мөр, чийрэг булчинлаг цээж, тэмээний таваг шиг том нударгатай нэгэн байлаа. Мавр Грасиелаг унтаж байхад ирсэн болохоор охин өглөө хөшиг татахдаа чармай шалдан эр орны дэргэдүүр өнгөрсөөр угаалгын өрөө рүү явж орохыг харжээ. Грасиела түүний үлэмж биеийг эзэнгүүт золтой л уулга алдчихсангүй.

“Энэ ч ээжийг минь алах нь дээ” хэмээн харуусан боджээ.

Охиныг гэнэт олж харсан Мавр цоо ширтэж,

-Байз, байз хө. Энд хэн гээч байна вэ? гэхэд нь,

Долорес Пинерью орноосоо огло харайн бууж ирээд, дэргэд нь зогсоод,

-Энэ миний охин хэмээн товчхон хариулав.

Грасиела бахим эрийн дэргэд чармай шалдан зогсож буй эхийгээ хараад аягүйцэн бүлтэлзэв. Мавр ам дүүрэн тэгш цагаан шүдээ ярзайлган инээж,

-Хөөрхөн охин минь, чамайг хэн гэдэг вэ? гэлээ.

Шалдан мөртлөө ажиг ч үгүй зогсох мань эрийг харан аягүйрхэхдээ

Грасиела юу ч дуугарсангүй.

-Түүнийг Грасиела гэдэг юм. Наадах чинь донгио амьтан байгаа юм аа гэж эх нь хажуунаас нь хэлжээ.

-Их хөөрхөн юм аа. Чамайг залуудаа ийм л сайхан амьтан байсан гэхэд эргэлзэх юм алга.

-Би одоо ч залуугаараа байна гэж ундууцсан Долорес үгийг нь таслаад охиндоо хандан,

-Алив хувцасла. Чи сургуулиасаа хоцрох нь гэжээ.

-За, ээж ээ.

Мавр зогссон тэр янзаараа охины араас харсаар байв. Эх нь түүний гараас чангаан аалиггүйгэж,

-Алив, орондоо орцгооё, хонгор оо. Бид гүйцээгээгүй байгаа шүү дээ гэхэд,

-Байж бай гээд Мавр Грасиелаг харсаар зогсов.

Мавр тэднийд төвхнөөд авлаа. Грасиела өдөр болгон сургуулиасаа ирэхдээ түүнийг явчихсан байгаасай гэж залбирна. Сайхь эр үл ойлгогдох

шалтгаанаар охинд нэг л хачин айдас төрүүлэх болжээ. Тэрээр охинтой

төдийлөн харьцахгүй ч гэлээ түүнд илт элэгсэг хандах хэдий ч түүний тухай

Өчүүхэн төдий бодохын зуурт охины хамаг бие салгалан чичирдэг болов.

Харин мань эр эхэд нь тэс өөрөөр хандах ажгуу. Мавр Долоресийн хөлөө эцээж, хөлсөө дуслуулж олсон хэдэн бор мөнгийг хуу хамаад ихэнх цагаа хажуугийн бааранд лонх хүзүүдэн өнгөрөөнө. Грасиела зарим шөнө Мавр эхийг нь зодож байхыг элэг эмтрэн сонсдог болсон бөгөөд өглөө эхийнх нь нүд булуу болтлоо нүдүүлж хөхөрсөн, эсвэл уруул нь сэт цохиулж бамбайн хавдсан босч ирэх болжээ.

-Ээж ээ, чамд энэ араатны хэрэг юу байна? гэж Грасиела тэсгэл алдан асуухад,

-Чи юуг нь ойлгох вэ? Тэр чинь бусад өчүүхэн амьтад шиг биш. Жинхэнэ эр хүн. Мавр эмэгтэй хүнд юу хэрэгтэйг сайн мэддэг юм гэснээ гэнэт учир

зүггүй аалиггүйтэн,

-Тэгээд ч тэр надад ухаангүй хайртай гэжээ.

Грасиела үүнд огт итгэсэнгүй, харин Мавр эхийг нь ердөө л ашиглаж буйг мэдэх авч эсэргүүцэж төвдсөнгүй. Охин эхийнхээ ухаанаа алдсан мэт уурсахаас ихэд айдаг ажээ. Нэг удаа олон “ах” нарын нэгэнд Грасиела цай аягалж зүрхэлснээс болж эх нь түүнийг хутга барин элдсэн удаатай.

Грасиела ням гаригийн өглөө сүм явахаар зэхэж, эх нь оёж бэлэн болсон палааж хүргэж өгөхөөр эртлэн гараад явсан байлаа. Грасиела унтлагын хувцсаа дөнгөж тайлтал хаалт болсон хөшиг нь хөдлөн шав шалдан Мавр ороод иржээ.

-Үзэсгэлэнт охин минь, ээж чинь хаачив?

-Ээж захиалсан хувцсыг нь аваачиж өгөхөөр эрт явсан.

Мавр Грасиелагийн нүцгэн биеийг өлөн нүдээр цоргин ширтэж,

-Чи үнэхээр үзэсгэлэнтэй юм хэмээн эелдэгээр хэлэхэд Грасиелагийн нүүр галд ойртох мэт халуу дүүгээд ирлээ. Охин хэрхэх ёстойгоо мэднэ. Тэрээр нүцгэн биеэ таглан цамц, банлаа углаж аваад явах ёстой. Гэвч охин байрнаасаа ч хөдөлж чадахгүй зогссоор, эр хүний тачаадах эрхтэн нүдэн дээр нь гандайн хатуурч, босохыг харан зогсоно. Охины чихэнд “Хурдан, хурдан... лавхан шургуул” гэх үгч цуурайтах шиг болжээ.

Грасиелагийн ухаан балартан толгой нь эргэж золтой л унасангүй.

-Чи ч шал нялхаараа амьтан байна. хувцаслаад явж үз гэж Мавр хоолой нь сөөнгөтөн хэлэв.

Санаандгүй байтал Грасиелагийн ухаан сийрэн, хүдэр эр тийш дөхөж очоод

гараа сунган бүсэлхийгээр нь тас тэвэрч, хүч нь зангирсан эр биеийг

мэдрэн,

-Үгүй ээ, би хүүхэд биш гэж гийнав.

Ийнхүү хэлүүт юутай ч зүйрлэшгүй шаналгаа мэдрэгдэн, охин тэсвэрлэхийн

эцэсгүй зовиурыг амсан байтал Мавр бахим гараараа тас тэврэн авав. Охин

хөөрөн дуу алдаж, тэд хос бэлгэсийг мэдэрч “Өнөөх нууцын учир ийм байдаг

байна шүү” хэмээн Грасиела боджээ. Орчлонт хорвоогийн нууцыг мэдэж,

түүний өчүүхэн хэсэг болон амьдралын жинхэнэ мөнхийн баяр бахдлыг

мэдэрнэ гэдэг юутай гайхамшигтай юм бэ!

-Та нар чинь юу болж байгаа нь энэ вэ? гэж Долорес Пинерьогийн чарлах

сонсогдсонн тэр агшинд бүх юм, цаг хугацаа хүртэл зогсчих шиг боллоо. Эх

нь охин, Мавр хоёрыг харан орны дэргэд зогсож байх нь тэр.

Айх, гайхах нь зэрэгцэн дуугарч чадахаа больсон Грасиела эхийгээ гөлийн ширтэнэ. Долоресийн нүдэнд ухаан зулаггүй уурсах хилэн тодорч,

-Аа чи муу гичий! Чи муу өөдгүй новш! хэмээн чарлалаа.

-Ээж ээ, гуйя чамайг ...

Орны дэргэд зогсож байсан Долорес хүнд төмөр үнсний сав шүүрэн авч, охиныхоо тархин дундуур хамаг чадлаараа буулгалаа. Энэ нь Грасиелагийн санаж буй хамгийн сүүлчийн дүр зураг байлаа.

Грасиела ор болгон дор бүрнээ эзэнтэй олон ор эгнүүлэн тавьсан эмнэлгийн саруулхан тасагт сэрлээ. Тэрээр бусад өвчтөний өвсөндөө тэсгэл алдан ёолох, дуу алдахыг сонсон хэвтэв.

Нэлээд орой орных нь дэргэд залуухан, насаар гучаас нэг их хэтрээгүй атлаа ядарсандаа их л оворжуу харагдах нэн эмч хүрч ирэн,

-За ухаан орох шив дээ гэж хэлэв.

-Би хаана байна? гэж дуугарах нь Грасиелад тун ч шаналгаатай байв.

-Чи Авила хотын захад оршдог эмнэлгийн тэтгэлгийн тасагт байна. Чамайг өчигдөр манайд авчирсан. Чиний духан дээр оёдол тавих хэрэгтэй болсон байна лээ. Манай ахлах мэс засалч чамайг сорвитой явна гэхэд дэндүү үзэсгэлэнтэй юм гээд өөрөө гардан оёдол тавихаар шийдсэн шүү гэлээ.

“Тэр алд, дэлэм эндүүрч дээ. Сорви бүх насаар минь үлдэх болно” гэж

Грасиела бодлоо.

Маргааш нь гэгээнтэн Перес Грасиелаг эргэн иржээ. Асрагч ламтанд

зориулан орных нь дэргэд сандал дөхүүлж өгөв. Гэгээнтэн цонхийн цайсан

үзэсгэлэнтэй охиныг хараад зүр нь шимширчээ. Охинд тохиолдсон аймшигт явда Лас-Невас-Дель-Маркес хот даяар шуугиан дэгдээсэн боловч одоо юуг ч өөрчилж чадахгүй нь гачлантай. Долорес Пиньеро охин нь унаад өөрөө толгойгоо хагалсан гэж мэдүүлжээ.

-Бие чинь дээрдэж байна уу, охин минь? гэж Перес ламтан асуув.

Грасиела толгой дохивол хүнд алхаар тонших мэт тархи нь луг лугхийн өвдөв.

-Цагдаагийнхан юу болсныг мэдэхийг хүсч байна. Чи надад ямар нэгэн юм хэлэхгүй биз? гэлээ.

Удтал дуугүй болсны эцэст,

-Би уначихсан юм аа гэж охин хариулжээ.

Ламтан охины нүдийг эгцлэн хар үл тэвчин,

-Ойлгож байна гэлээ.

Гэгээн эцэг охинд хэлэх гэж буй үгээ бодохоос зүрх нь шимшрэх ажээ.

-Грасиела би ээжтэй чинь уулзсан ... хэмээн түгдэртэл Грасиела бүгдийг нь ойлгон,

-Би гэртээ эргэж очиж болохгүй, тийм үү? гэв.

-Тийм л болоод байна даа. Энэ талаар бид дахин ярилцана аа. Маргааш чамайг эргэж ирнэ ээ гээд ламтан гарыг нь чангаар атгав.

-Баярлалаа, гэгээн эцэг минь.

Түүнийг явснаас хойш Грасиела “Энэрэнгүй бурхан минь, надад үхэл хайрлаач. Би амьд явахыг хүсэшгүй нь” хэмээн залбирчээ.

Охинд хаашаа ч, хэн рүү ч очих газар байсангүй. Тэрээр төрсөн гэрийнхээ босгыг давах эрхгүй болж, сургуулийнхаа танил болсон багш нарын царайг дахин харахгүй. Түүний хувьд энэ ертөнц дээр юу ч үлдсэнгүй.

Асрагч орных нь дэргэд зогсон,

-Чамд ямар нэг юм хэрэгтэй юу? гэж асуухад нь юу хэлэх билээ хэмээн цөхөрсөн Грасиела түүнийг хий гөлийн ширтэв.

Маргааш өдөр нь өнөөх залуу эмч хүрч ирэн,

-Би сайхан мэдээ дуулгахаар ирлээ. Чи эв эрүүл болсон, гарч болно шүү гэж хэлсэн нь үнэмшилгүй сонсогдон, харин түүний “Бидэнд сул ор хэрэгтэй болоод байна” гэж нэмж хэлсэн нь чин үнэн үг байлаа.

Тэр хаачих билээ?

Перес ламтан бас нэг ламыг дагуулсаар ирэв.

-Энэ миний хуучин анд, эцэг Беррандо хэмээн танилцуулав. Грасиела

эцэнхий гэгээнтнийг харан,

-Сайн байна уу, гэгээн эцэг минь гэлээ.

“Түүний зөв байжээ. Охин үнэхээр үзэсгэлэнтэй юмаа” гэж эцэг Беррандо боджээ.

Перес ламтан Грасиелад тохиолдсон явдлыг ярив. Ламтан хахир хатуу амьдрал туулсан охиныг өрөвдөн хайрлуулах гэсэн шинж тодрох болов уу гэвэл охины царай юуг ч эс илэрхийлнэ.

-Чамд ийм хэцүү явдал тохиолдсонд надад тун хэцүү байна гэж Беррандо түүнд хандан хэлэв.

Энэ үгний цаана нэг нууцлаг шалтгаан халхлагдана.

-Грасиела, би Лас-Невас-Дель-Маркес руугаа буцах хэрэгтэй байна. Би чамайг Беррандо ламтны асрамжинд үлдээе гэж Перес ламтанг хэлэхэд Грасиела гэнэт цочирдон, гэртэй нь холбож байсан эцсийн учиг тасрах шиг санагдаад явчихжээ.

-Битгий яваач хэмээн охин мөргөн гуйлаа.

Перес ламтан гарыг нь чангаар атган,

-Чамайг ганцаардаж байгааг мэдэж байна. Гэхдээ тийм биш шүү. Надад итгэ, хүү минь. чи ганцаардахгүй гээд духыг нь энхрийлэн илэв.

Асрагч баадантай юм барьсаар орных нь дэргэд ирж, Грасиелад сарвайн,

-Энэ чиний хувцас. Харамсалтай нь чи явах болжээ гэв.

Охин бүр ч сандран тэвдэж,

-Яг одоо юу? гэлээ.

Лам нар харц солилцсоноо,

-Яагаад чи хувцсаа өмсөөд надтай хамт явж болохгүй гэж. Бид ярилцаж болно шүү дээ гэж Беррандо ламтан санал болгов.

Арван таван минутын дараа гэхэд Берранда лам Грасиела хоёр эмнэлгийн хаалгаар халуунаар төөнөх нарны гэрэлд гарлаа. Эмнэлгийн урд тал дахь цэцэрлэгт тод өнгийн ганган цэцэгс ургасан байх авч сэтгэл нь үймэрсэн Грасиела огт анзаарсангүй.

Тэд Беррандо ламтаны өрөөнд сууж байлаа.

-Перес ламтан чамд очих газар байхгүй гэж хэлсэн гэвэл Грасиела толгой дохив.

-Садан төрлийн хүн баайхгүй юу?

-Ганцхан ... гээд түгдрэх охинд энэ үгийг хэлэх нь тун ч хэцүү санагдан

“Ганцхан ээж минь бий” гэлээ.

-Перес ламтан чамайг хотынхоо хийдэд байна очдог гэсэн.

“Миний дахиад харахгүй тэр л хотод”.

-Тийм ээ.

Грасиела ням гариг бүр хийдэд очдог байснаа, уншлагын үеэр ямар гоё байдгийг, тэрээр бурхантай учран золгож, амьдралын зовлонгоос нь ангижрахыг гуйж байснаа бодов.

-Грасиела чи хэзээ ч юм хийдэд очихыг хүсдэг байсан уу?

-Үгүй гээд охин зурсхийн орж ирсэн нэгэн бодлоосоо цочлоо.

-Энд Авилад нэгэн хийд байдаг юм. Энэ нь гэлэнмаа нарын хийд шүү. Тэнд

чамайг асран халамжилж болох юм.

-Би ... би мэдэхгүй гэж охиныг ламтны үг айлгаж орхижээ.

-Ийм амьдрал хэн хүнд заяадаггүй юм. Энэ хийд хамгийн хатуу дэгтэйг би чамд анхааруулах ёстой. Тийшээ орж гэлэнмаа болох л юм бол хийдийн оршин суугчдаа хэзээ ч орхиж явахгүй байх сахилыг чи өөрөө бурханд хүртээх болно хэмээн эцэг Беррандо намуухан дуугаар хүнгэнүүлэн хүүрнэв.

Грасиелагийн толгойд зөрчилтэй бодлууд эргэлдэн цонхоор гөлийн сууж, энэ ертөнцөөс тусгаарлагдана гэсэн санаа нь түүнийг түгшээлээ. “Шоронд орсонтой ялгаа юу байх вэ”. Гэвч тэр энэ орчлонгоос юу хүсэх билээ.

Тэсвэрлэхийн эцэсгүй зовиур шаналгаа. Тэрээр үе үе амиа хорлохыг боддог байжээ. Энэ нь түүний зовлонг эцэслэхсэн.

-Чи өөрөө л шийдэх ёстой хүү минь. Хэрэв хүсвэл би чамайг эх-даа гэлэнмаатай нь танилцуулъя хэмээн Беррандо ламтанг хэлэхэд,

-Тэгье гээд Грасиела толгой дохив.

Ширээт эх өмнөө суух охины царайг сонжино. Олон жилийн туршид сонсогдсон тэр дуу хоолой “Чам дээр бяцхан хүүхэд ирнэ. Түүнийг хамгаал” гэж хэлжээ.

-Хонгор минь, чи хэдтэй вэ?

-Арван дөрөвтэй.

“Боломжийн том болчихжээ”. IV зуунд Ромын Пап лам арван хоёр наснаас дээш насны охидыг гэлэнмаа болгон үсийг нь хусч сахил хүртээхийг зөвшөөрдөг болжээ.

-Надад аймшигтай байна гэж Грасиела ширээт эх Бетинад хэлэв.

-Грасиела бүү яар. Бурхан чамайг орхихгүй. Сайн бод, тэгээд эргээд ир. Тэр хоёул үүнийг ярилцъя гэжээ.

Гэтэл охин юун тухай бодох билээ. “Энэ хорвоод надад очих газар байхгүй.

Харин хийдийн нам гүм миний хүсэн хүлээсэн амар амлгалан мөн. Би тэр аймшигтай дуу авиаг дэндүү их сонссон” гэж Грасиела бодоод гэлэнмаа эх тийш харан,

-Би чив чимээгүй, амар амгаланг дуртайяа зөвшөөрнө гэжээ.

